

Азийн хөгжлийн банк, түүний зээлдэгч

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД МӨРДӨХ ЖУРАМ

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн болно. АХБ орчуулгыг аль болох үнэн зөв байлгахыг хичээдэг боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу.

Азийн хөгжлийн банк

2007 оны 2 дугаар сар

ӨМНӨХ ҮГ

Энэхүү *“Азийн хөгжлийн банк, түүний зээлдэгч зөвлөх үйлчилгээ авахад мөрдөх журам”* шинээр гарсантай холбогдуулан 2005 оны 1 дүгээр сард батлагдсан *“Азийн хөгжлийн банк, түүний зээлдэгч зөвлөх үйлчилгээ авахад мөрдөх журам”* -ыг хүчингүйд тооцов.

Энэ журмыг Азийн хөгжлийн банк (АХБ), тус банкны захиран зарцуулдаг бусад буцалтгүй тусламжийн сангаас санхүүждэг зээлийн болон техник туслалцааны (ТТ) төслийн зөвлөхийг сонгон шалгаруулахад мөрдөнө.

ГАРЧИГ

I.	УДИРТГАЛ	4
	Зорилго	4
	Ерөнхий заалтууд	2
	Хамрах хүрээ	3
	Ашиг сонирхлын зөрчил	4
	Шударга бус өрсөлдөөнт давуу тал	5
	Оролцох эрх	5
	Зөвлөхүүдийн хамтын байгууллага	6
	Урьдчилан гэрээ хийх ба нөхөн санхүүжүүлэх	6
	АХБ-ны хяналт, туслалцаа, мониторинг	7
	Хүчин төгөлдөр бус худалдан авах ажиллагаа	7
	АХБ-ыг дурьдах	8
	Чадавхийг хөгжүүлэх	8
	Сургалт явуулах буюу мэдлэг шилжүүлэх	8
	Хэл	9
	Хуурамчаар мэдүүлэх ба авилгал	9
	Ажлын үнэлгээ	11
	Худалдан авах төлөвлөгөө	11
II.	ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА	12
A.	Сонгон шалгаруулах аргууд	12
	1. Зөвлөх компанийг сонгон шалгаруулах	12
	а. Чанар-үнийг харгалзах сонголт (ЧҮХС)	12
	б. Чанарыг харгалзах сонголт (ЧХС)	16
	в. Батлагдсан төсвийг харгалзах сонголт (БТХС)	17
	г. Бага үнийг харгалзах сонголт (БҮХС)	18
	д. Зөвлөхийн ур чадварыг харгалзах сонголт (ЗУЧХС)	18
	е. Нэг эх үүсвэрийн арга (НЭҮА)	19
	ё. Арилжааны арга (АА)	20
	2. Зөвлөх хувь хүнийг сонгох	20
	3. Тусгай зөвлөх сонгон шалгаруулах	20
B.	Гэрээний төрлүүд	23
	1. Хугацааны гэрээ	23
	2. Тогтмол хөлс ба магадлашгүй ажлын хөлсний (үр дүнгийн) гэрээ	23
	3. Товлогдоогүй хугацаанд үйлчилгээ үзүүлэх гэрээ (Үнийн гэрээ)	24
	4. Бөөнд нь төлөх гэрээ (БТГ)	24
	5. Үр дүнд суурилсан гэрээ	24
B.	Зээлийн төслийн зөвлөх үйлчилгээний гэрээнд тусгагдах чухал заалтууд	25
Г.	Гүйцэтгэлийг хянах, үнэлэх	27
	Сонгон шалгаруулах явцыг хянах	27
	Гүйцэтгэлийг хянах	27
Хавсралт 1		29
	Чанар-Үнийг Харгалзах Сонголт , Чанарыг Харгалзах Сонголтоор	29
	Зөвлөх Сонгон Шалгаруулах Журмыг Хураангуйлан Үзүүлсэн Нь	29
Хавсралт 2		31
	Зээлийн Төслийн Зөвлөхөд Зориулсан Зөвлөмж	31

I. УДИРТГАЛ

Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зээл, буцалтгүй тусламж, эсвэл АХБ-ны захиран зарцуулдаг бусад сангийн хөрөнгөөр бүрэн болон хэсэгчлэн санхүүждэг зээлийн болон техник туслалцааны (ТТ) төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөхийг сонгон шалгаруулах, зөвлөхүүдтэй гэрээ байгуулах, тэдэнд хяналт тавихад баримталбал зохих бодлого, журмуудыг тодорхойлоход оршино. Энэ журамд зөвлөх үйлчилгээтэй холбогдолтой АХБ-ны бодлого, журмуудыг тусгасан бөгөөд илүү дэлгэрэнгүй мэдээллийг АХБ-ны Төслийн удирдлагын заавар (ТУЗ)¹ болон/эсвэл стандарт саналын урилгад (СУ)² багтаасан болно.

1.2 Зээл, тусламжийг авч буй этгээд ба АХБ-ны хоорондын эрх зүйн харилцаа нь тухайн нөхцлөөс хамааран зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ, эсвэл ТТ-ны гэрээгээр³ зохицуулагдах ба тухайн гэрээнд заасан зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахад энэхүү журмыг баримтална. Зээлдэгч⁴, АХБ болон зөвлөхийн эрх үүрэг нь зээлдэгч эсвэл АХБ-наас гаргасан тухайн СУ болон зээлдэгч эсвэл АХБ-ны зөвлөхтэй байгуулсан гэрээгээр зохицуулагдах бөгөөд харин энэхүү журам, зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ, ТТ-ны захидлан гэрээгээр зохицуулагдахгүй. Зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ, ТТ-ны захидлан гэрээний талуудаас өөр ямар ч талууд гэрээнд заагдсан эрх эдлэх, эсвэл зээл, буцалтгүй тусламж, ТТ-ны хөрөнгөөс нэхэмжлэх эрхгүй.

1.3 Энэхүү журамд заасан “зөвлөхүүд” гэдэг нэр томъёонд хувийн хэвшлийн болон төрийн өмчийн өргөн хүрээний хуулийн этгээдүүд, түүний дотор олон улсын⁵ болон дотоодын⁶ зөвлөх, зохион бүтээх, барилгын, удирдлагын үйлчилгээ үзүүлдэг компаниуд, худалдан авах ажиллагааны төлөөлөгч, хянан шалгах төлөөлөгч, аудитын хянан шалгагч, НҮБ-ын байгууллагууд, болон бусад олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, их сургуулиуд, судалгааны байгууллагууд, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллага

¹ ТУЗ-г АХБ-ны вэбсайт www.adb.org –аас үзэж болно.

² Зээлийн төсөлд хэрэглэгддэг стандарт саналын урилгыг бусад олон талт хөгжлийн банкуудынхтай бүрэн хэмжээгээр нийцүүлсэн ба АХБ-ны вэбсайт www.adb.org –аас үзэж болно.

³ АХБ ба ТТ-г хүлээн авагч улс орны хоорондын харилцааг АХБ-наас тухайн оронд олгосон бүх ТТ-д хамаарах нэгдсэн нэг ерөнхий гэрээгээр зохицуулдаг. Үүнээс гадна ТТ нэг бүр дээр АХБ, хүлээн авагч улс орон хоёр ТТ-ны захидлан гэрээг байгуулдаг. ТТ-ны захидлан гэрээнд ихэвчлэн ТТ-ны ерөнхий гэрээ, ТТ-ны төслийг батлуулахыг санал болгосон төслийн баримт бичгийн холбогдох заалтуудыг багтаасан байдаг.

⁴ Зээлдэгч эсвэл буцалтгүй тусламжийг хүлээн авагч АХБ-ны санхүүжилттэй төслийг өөрөө шууд хэрэгжүүлээгүй тохиолдолд энэхүү журамд заасан “зээлдэгч” гэдэг нэр томъёонд гүйцэтгэгч эсвэл хэрэгжүүлэгч агентлагууд багтана.

⁵ “Олон улсын зөвлөх” гэж АХБ-ны аль нэг гишүүн оронд үүсгэн байгуулагдсан зөвлөх компани эсвэл АХБ-ны гишүүн аль нэг орны түүний дотор зээлдэгчийн улс орны иргэн хувь хүнийг хэлнэ.

⁶ “Дотоодын зөвлөх” гэж зээлдэгчийн улс оронд үүсгэн байгуулагдсан, тэнд бүртгэлтэй зөвлөх компани эсвэл зээлдэгчийн улс орны иргэн хувь хүнийг хэлнэ.

(ТББ)-ууд болон хувь хүмүүсийг⁷ ойлгоно. АХБ болон түүний зээлдэгчид нь бодлогын зөвлөмж, бүтцийн шинэчлэл, удирдлагаар хангах, барилгын ажилд хяналт тавих, зохион бүтээх, санхүүгийн, худалдан авах үйлчилгээ үзүүлэх, нийгмийн болон байгаль орчны судалгаа хийх, төсөл тодорхойлох, бэлтгэх, хэрэгжүүлэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаанд туслалцаа авч эдгээр чиглэлийн чадавхаа дээшлүүлэх зорилгоор зөвлөх авч ажиллуулдаг.

Ерөнхий заалтууд

1.4 Ерөнхийдөө зээлийн⁸ хөрөнгөөр санхүүжигдэх зөвлөхүүдийг сонгон шалгаруулах, ажиллуулах, тэдэнд тавих хяналтыг зээлдэгч хариуцдаг бол ТТ-ны буцалтгүй тусламжийн⁹ хөрөнгөөр хөлслөх зөвлөхүүдийг сонгон шалгаруулах, ажиллуулах, тэдэнд тавих хяналтыг АХБ хариуцдаг. Зөвлөхүүдийг ажиллуулахад баримтлах журам нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалах хэдий ч АХБ-ны зөвлөх сонгон шалгаруулах үйл явц нь дараахь үндсэн зургаан зарчимд захирагддаг. Үүнд:

- а) өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх шаардлага;
- б) хэмнэлт, үр ашиг өгөх шаардлага;
- в) АХБ-ны санхүүжилттай зөвлөх үйлчилгээ үзүүлэх шалгаруулалтад шаардлага хангасан бүх зөвлөхүүд оролцон өрсөлдөх боломж бүрдүүлэх;
- г) Хөгжиж буй гишүүн орнууд (ХБГО)-ын дотоодын зөвлөх үйлчилгээг хөгжүүлэн тэдгээрийг ажиллуулах нь АХБ-ны сонирхол байх;
- д) Сонгон шалгаруулах үйл явцыг ил тод явуулах;
- е) Авилгалын эсрэг тэмцэх болон ёс зүйн хэм хэмжээг сахихад анхаарлаа улам дээшлүүлэх

1.5 Сонгон шалгаруулалтын шаардлага ханган хураангуй жагсаалтад орсон зөвлөх компаниудыг хооронд нь өрсөлдүүлж тэдний саналын чанар болон шаардлагатай бол үйлчилгээний үнэ өртөг дээр үндэслэн дотор нь сонгон шалгаруулах маягаар дээрх зарчмуудыг хангах бололцоотой гэж АХБ үздэг. Энэ журмын II бүлгийн А хэсэгт АХБ-наас зөвшөөрсөн зөвлөх шалгаруулах төрөл бүрийн аргууд, тэдгээрийг хэрэглэх нөхцлүүдийн талаар өгүүлэв. Чанар ба үнэд үндэслэн сонгох аргыг (ЧҮА) АХБ илүү эрхэмлэдэг тул энэхүү журмын 2.2–2.21 дүгээр зүйлд ЧҮА-ыг хэрэглэх журмын талаар дэлгэрэнгүй тайлбарласан болно. ЧҮА тохиромжгүй үед хэрэглэх бусад аргын талаар 2.23 – 2.32 зүйлд өгүүлсэн.

⁷ “Зөвлөх хувь хүн”-ий талаар 2.34 дүгээр зүйлийг үз.

⁸ Үүнд Азийн хөгжлийн сан (АХС)-гийн буцалтгүй тусламжаар бүхэлдээ болон хэсэгчлэн санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төслүүд дээр ажиллах зөвлөхүүд багтана.

⁹ ТТ-ны төслийн өмчлөлийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор зарим нэг тодорхой тохиолдолд ТТ-ны төслийн зөвлөх сонгон шалгаруулах, хянах үүрэг хариуцлагыг АХБ зээлдэгчид шилжүүлж болно (“зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөл” гэх).

1.6 Зээл, ТТ-ны төслийн зөвлөх сонгон шалгаруулахад хэрэглэж болох аргуудын талаар тухайн зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ, эсвэл ТТ-ны захидлан гэрээнд дурьдсан байдаг. Төслийн хүрээнд байгуулах тодорхой гэрээнүүд, түүний гүйцэтгэгчийг зээл, буцалтгүй тусламж, эсвэл ТТ-ны гэрээнд нийцүүлэн сонгон шалгаруулах тухайд тэдгээрийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд заана. (1.27 дугаар зүйлийг үз.)

Хамрах хүрээ

1.7 Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн, өргөн хүрээний салбарыг хамарсан, төслийн бүх шатыг хамарсан өргөн хүрээний¹⁰, оюуны болон зөвлөх шинж чанартай үйлчилгээ авахад энэхүү журмыг мөрдөнө. Үйл ажиллагааны биет бодит шинж чанар нь давамгайлсан бусад төрлийн үйлчилгээнд (барилгын ажил гм.) энэ журам хэрэглэгдэхгүй.

1.8 АХБ-ны зээл, ТТ, бусад буцалтгүй тусламж, эсвэл АХБ-ны захиран зарцуулдаг сангийн хөрөнгөөс бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүжүүлэх, АХБ, эсвэл зээлдэгчийн хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний бүх гэрээнд энэхүү журмыг баримтлана. Эдгээрээс бусад эх үүсвэрийн санхүүжилтээр зөвлөх үйлчилгээг худалдан авах тохиолдолд зээлдэгч өөр журам баримталж болно. Энэ тохиолдолд (i) сонгосон журам нь шаардлагатай мэргэжлийн мэдлэг чадвар бүхий зөвлөхүүдийг сонгон шалгаруулахуйц байх (ii) сонгосон зөвлөхүүд нь тохирсон хуваарийн дагуу үүрэг даалгавраа гүйцэтгэх (iii) зөвлөх үйлчилгээний цар хүрээ нь төслийн хэрэгцээнд нийцсэн байх ёстой гэж АХБ үздэг.

1.9 Зээлдэгч нь зөвлөхийг зээлийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төслийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх компани, хувь хүнээс сонгоно. АХБ-ны өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлдэг, эсвэл өөр байгууллагын хөрөнгөөр санхүүжүүлдэг боловч тухайн байгууллагын нэрийн өмнөөс АХБ хэрэгжүүлдэг ТТ-ны төсөлд АХБ зөвлөх үйлчилгээ авч болдог. Үүнээс гадна АХБ (i) өөрийн боловсон хүчнийг нөхөх зорилгоор “ажилтан-зөвлөх” авч ажлуулдаг ба тэднийг мэргэжлийн тусгай мэдлэг, зөвлөгөөгөөр хангаж гэрээг нь АХБ-ны захиргааны төсвөөс санхүүжүүлдэг. (ii) хурал, семинар зохион байгуулах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор нөөц хүн авч болно. Энэ тохиолдолд зөвлөхийг АХБ сонгоно. Зөвлөхийн үүрэг хариуцлагыг ажлын даалгаварт нарийн тодорхойлж өгөх ба ТТ-ны төслийн зөвлөхийн ажлын даалгаврыг ТТ-г хүлээн авагч этгээдтэй хамтран боловсруулна.

¹⁰ “Үйлчилгээ”-нд бодлогын зөвлөгөө өгөх; засаглал; бүтцийн өөрчлөлт хийх; нийгмийн асуудлууд түүний дотор ядуурлыг бууруулах ба жэндерийн асуудлуудыг авч үзэх; байгаль орчны үнэлгээ, аудит хийх, оролцоогоор хангах ба зөвлөлдөх, байгууллагыг бэхжүүлэх, сургалт зэрэг чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах; эрх зүйн болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, менежментийн болон инженерийн үйлчилгээ үзүүлэх; болон барилгын ажилд хяналт тавих зэрэг орно.

Ашиг сонирхлын зөрчил

1.10 Тухайн этгээд албан үүрэг, хариуцлагаа гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хууль тогтоомж мөрдөхөд нь зүй бусаар нөлөөлөхүйц ашиг сонирхолтой бөгөөд тэрхүү ашиг сонирхлын зөрчил нь АХБ-ны авилгалын эсрэг бодлогод хориглосон үйл ажиллагааг бүрдүүлэхэд нөлөөлсөн, эсвэл бүрдүүлсэн бол түүнийг АХБ ашиг сонирхлын зөрчил гэж үзнэ. АХБ-ны авилгалын эсрэг баримталдаг бодлого нь зээлдэгчдийг (АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шимийг хүртэгчид) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлэх зөвлөхүүдээс ёс зүйн дээд зэргийн хэм хэмжээ баримтлахыг шаарддаг. Хэрэв ашиг сонирхлын зөрчлийн улмаас аливаа зөвлөх сонгон шалгаруулах үйл явц шударга бус явагдсан гэж АХБ үзвэл уг ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах арга хэмжээ авах, эсвэл гэрээ байгуулах эрх олгохоос татгалзах эрхтэй.

1.11 Дээрх зүйлийн ерөнхий заалтаар хязгаарлахгүйгээр дор дурьдсан нөхцөлд зөвлөх хөлсөлж ажлуулахыг хориглоно:

(а) **Зөвлөх үйл ажиллагаа ба бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс¹¹ бусад) худалдан авах ажлын хооронд зөрчил үүсэх.** Аливаа төсөлд зориулан бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс бусад) нийлүүлэхээр АХБ болон зээлдэгчийн хөлсөлсөн зөвлөх компанид болон хувь хүнд тэдгээр бараа, ажил, үйлчилгээтэй холбогдолтой зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх олгогдохгүй. Үүнчлэн аливаа нэг төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр ажилласан зөвлөх компани, хувь хүн нь тийнхүү боловсруулсан, хэрэгжүүлсэн төслөөс үүдэн гарсан, эсвэл түүнтэй шууд холбоотой бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс бусад) нийлүүлэх эрхгүй.

(б) **Зөвлөх ажлуудын хоорондын зөрчил.** Зөвлөх компани, эсвэл хувь хүнийг түүний өөр ажил үүрэгтэй нь зөрчилдөж болох аливаа ажил гүйцэтгүүлэхээр хөлсөлж болохгүй. Жишээлбэл: Дэд бүтцийн төслийн инженерийн зураг төслийг боловсруулсан зөвлөх компани, эсвэл хувь хүн мөн төслийн байгаль орчны хөндлөнгийн үнэлгээг хийж болохгүй. Төрийн өмчийг хувьчлахад тусалж буй зөвлөх компани, эсвэл хувь хүн тухайн өмчийг худалдан авах эсвэл худалдан авагчид зөвлөгөө өгч үл болно. Үүнтэй адилаар ажлын даалгавар боловсруулсан зөвлөхүүдийг тухайн даалгаврыг гүйцэтгүүлэхээр хөлсөлж болохгүй.

(г) **Зээлдэгчийн ажилтнуудтай харьцаатай байх.** (i) гэрээний ажлын даалгавар боловсруулах, (ii) гэрээ гүйцэтгэгчийг шалгаруулах (iii) гэрээнд хяналт тавихад шууд буюу шууд бус ямар нэг байдлаар оролцдог АХБ-ны, эсвэл зээлдэгчийн ажилтантай бизнесийн эсвэл гэр бүлийн харилцаатай, тэрхүү харилцаанаас үүдэн гарах ашиг сонирхлын зөрчлийг сонгон шалгаруулах ба гэрээг гүйцэтгэх бүхий л хугацаанд АХБ-ны

¹¹ Энэ журмын 1.7 дугаар зүйлийг үз.

шаардлагад нийцэхүйцээр шийдвэрлэж чадаагүй бол тэрхүү зөвлөх компани, хувь хүнтэй гэрээ байгуулах эрх олгож үл болно.

Шударга бус өрсөлдөөнт давуу тал

1.12 Сонгон шалгаруулах явцыг шударга, ил тод явуулах шаардлагын улмаас аливаа нэг ажлыг гүйцэтгэхээр өрсөлдөж буй зөвлөх компаниуд, хувь хүмүүс тухайн ажилтай холбогдолтой зөвлөх үйлчилгээг өмнө нь үзүүлж байсныгаа давуу тал болгохыг зөвшөөрдөггүй. Иймд АХБ, эсвэл зээлдэгч хураангуй жагсаалтад орсон бүх зөвлөхөд тэнцүү өрсөлдөх боломж өгөхүйц бүхий л мэдээллийг саналын урилгын хамт явуулна.

Оролцох эрх

1.13 АХБ өөрийн санхүүжүүлэх төсөлд өрсөлдөөнийг дэмжих зорилгоор АХБ-ны бүх гишүүн орны компани, хувь хүмүүст төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрдөг. Тендерт оролцоход тавигдах аливаа нөхцлүүд нь компаний тухайн гэрээг гүйцэтгэх чадварыг баталгаажуулахад зайлшгүй шаардлагатай нөхцлүүдээр хязгаарлагдана. Гэхдээ доорхи зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- (a) НҮБ-ын Дүрмийн VII бүлэгт заагдсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрт нийцүүлэх үүднээс ямар нэг улс орон, хувь хүн, хуулийн этгээдэд төлбөр хийхийг зээлдэгчийн улс орон хориглосон бол тухайн орны зөвлөхүүдийг тендерээс хасч болно. Ийм шалтгаанаар зээлдэгчийн улс орон тодорхой нэг зөвлөх, эсвэл үйлчилгээнд төлбөр хийхийг хориглосон бол тухайн зөвлөхийг тендерээс хасч болно.
- (б) (i) эрхзүй, санхүүгийн хувьд биеэ даасан (ii) арилжааны хуулиар үйл ажиллагаагаа явуулдаг (iii) зээлдэгч болон дэд зээлдэгчийн харъяа байгууллага биш гэдгээ баталсан тохиолдолд зээлдэгчийн улс орны төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газрууд тендерт оролцохыг зөвшөөрнө.
- (в) Зээлдэгчийн улс орны төрийн өмчийн их сургууль, судалгааны төв нь өөр хаана ч байхгүй цорын ганц, онцгой шинж чанартай үйлчилгээ үзүүлдэг бөгөөд төсөл хэрэгжүүлэхэд тэдний оролцоо зайлшгүй шаардлагатай бол тэдгээр байгууллагыг авч ажиллуулах асуудлыг АХБ-наас зөвшөөрч болох бөгөөд чингэх тохиолдолд тухайн нөхцөл тус бүрийг тусгайлан авч үзнэ.
- (г) Дараахь тохиолдолд төрийн албан тушаалтан, албан хаагч нь хувь хүн, эсвэл зөвлөх компанийн багийн гишүүн хэлбэрээр зөвлөх үйлчилгээ үзүүлж болно. Үүнд: (i) хэрэв тэд үндсэн ажлаасаа цалингүй чөлөөтэй байгаа бол;(ii) чөлөө авахаасаа өмнө ажиллаж байсан байгууллагадаа зөвлөх үйлчилгээ

үзүүлэх гэж байгаа бус бол; (iii) тэдгээрийг авч ажиллуулснаас ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол. (1.10 дугаар зүйлийг үз.)

- (д) Энэ журмын 1.23-ийн “г” дэд зүйлд заасны дагуу тендерт оролцох эрхгүй хэмээн тодорхойлогдсон зөвлөхөд АХБ-ны санхүүжүүлэх, эсвэл удирдан хэрэгжүүлэх гэрээг байгуулах эрхийг тус банкнаас заасан хугацаанд олгож болохгүй.

Зөвлөхүүдийн хамтын байгууллага

1.14 Зөвлөхүүд нь өөрсдийн мэргэшлийн дутуу салбар, чиглэлийг нөхөх, өөрсдийн саналын техникийн шаардлагыг хангах чадварыг дээшлүүлэх, мэргэжилтнүүдийн нөөцөө ихэсгэх, илүү сайн арга зам, арга зүйгээр хангах, зарим тохиолдолд илүү хямд үнэ санал болгох зорилгоор хамтарсан компаний¹² хэлбэрээр, эсвэл туслан гүйцэтгэх гэрээ байгуулах маягаар хоорондоо нэгдэж болно. Ийм холбоо нь урт хугацаанд (ямар нэг тодорхой ажлаас үл хамааран), эсвэл зөвхөн нэг ажлыг гүйцэтгэх хугацаанд үргэлжилж болно. Хэрэв АХБ, эсвэл зээлдэгч хэд хэдэн компаниас бүрдсэн хамтарсан компанийг хөлслөх бол тэдгээр компаниуд дундаасаа хамтарсан компанийг төлөөлөх нэг компанийг томилж бүх гишүүд гэрээнд гарын үсэг зурах ба компаниуд бүгдээрээ болон тус бүрдээ ажлыг бүхэлд нь хариуцна. Зээлдэгч нь зөвлөхүүдийг ямар нэг тодорхой компани, эсвэл хувь хүнтэй хэлхээ холбоо байгуулахыг шаардах эрхгүй боловч шаардлага хангасан дотоодын компанитай хамтран ажиллахыг дэмжиж болно.

Урьдчилан гэрээ хийх ба нөхөн санхүүжүүлэх

1.15 Шаардлагатай үед төслийн хэрэгжилтийг түргэвчлэх зорилгоор зээлдэгч нь зөвлөх үйлчилгээг урьдчилан гэрээлж дараа нь санхүүжилт авахыг АХБ зөвшөөрнө. Зээлийн гэрээ байгуулагдахаас өмнө зээлдэгч АХБ-ны зөвшөөрөлтэйгээр зөвлөх сонгон шалгаруулалтыг (гэхдээ гэрээ байгуулахгүй) эхэлж болно. Энэ тохиолдолд сонгон шалгаруулалтад баримталсан журам нь энэхүү журамтай нийцсэн байх ёстой бөгөөд АХБ зээлдэгчийн сонгон шалгаруулсан үйл явцыг хянан үзнэ. Зээлдэгч нь тийнхүү урьдчилсан гэрээ байгуулахдаа өөрөө эрсдэл хүлээж байгаа бөгөөд хэрэглэсэн журам, баримт бичиг, эсвэл гэрээ байгуулах эрх олгох саналыг нь зөвшөөрсөн АХБ-ны аливаа зөвшөөрөл нь АХБ тухайн төслийг заавал санхүүжүүлэх үндэслэл болохгүй. Төслийн зээлийн гэрээ байгуулагдахаас өмнө зөвлөх үйлчилгээний дээр өгүүлэгдсэн урьдчилсан гэрээ байгуулагдаж, түүний хүрээнд зээлдэгчийн хийсэн аливаа төлбөрийг АХБ-наас нөхөн олгохыг нөхөн санхүүжүүлэх гэх ба зээлийн гэрээнд заасан хязгаарын хүрээнд зөвшөөрдөг.

¹² Хураангуй жагсаалтад оруулах зорилгоор хамтарсан компаний (ХК) улс орны харьяалалыг тодорхойлохдоо ХК-ийг төлөөлөгч компаний харьяалалыг иш үндэс болгоно.

АХБ-ны хэрэгжүүлэх ТТ-ны төсөл, эсвэл зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөл дээр зөвлөх урьдчилан авч ажлуулахыг тодорхой нөхцөлд зөвшөөрч болно.

АХБ-ны хяналт, туслалцаа, мониторинг

1.16 Зээлдэгчээр энэ журмыг мөрдүүлэх зорилгоор зээлийн төслийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөл дээр зөвлөх авч ажиллуулахын өмнө АХБ хяналт тавьдаг. АХБ ийнхүү өмнө нь хяналт хийхдээ сонгон шалгаруулалтын аль ч арга хэрэглэгдсэн байлаа ч зөвлөх авч ажиллуулах явцын янз бүрийн үе шатанд АХБ-нд материалаа явуулан зөвшөөрөл авахыг зээлдэгчээс шаарддаг. Өмнөх хяналт хийгдэх давтамж, цар хүрээ нь зээлдэгчийн чадавхиас шалтгаална. Чадавхи сайтай, туршлагатай зээлдэгчээс цөөн тооны материал шаардана. Зарим тохиолдолд сонгон шалгаруулсан хойно нь хяналт хийх үүднээс өмнө нь хяналт хийдэггүй. Өмнөх хяналтын давтамж, цар хүрээ, шаардлагууд мөн хожим нь хяналт хийх шаардлагатай гэрээний босго үнийн талаар зээлдэгч, АХБ нар төсөл бэлтгэж байх явцдаа тохирч ажил, үйлчилгээ авах төлөвлөгөөнд тусгана. (1.6; 1.27 дугаар зүйлүүдийг үз.)

1.17 Онцгой нөхөл байдалд, тухайлбал сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн хүсэлтийн тоо хангалтгүй, эсвэл зээлдэгчээс АХБ-нд бичгээр хүсэлт гаргасан бол тухайн ажлыг биелүүлэх чадвартай гэж өөрийн үзэж буй зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалтыг АХБ зээлдэгчид гаргаж өгнө. Энэ жагсаалт нь уг жагсаалтад нэр нь багтсан зөвлөхүүдийг сонгох ямар нэг зөвшөөрөл болохгүй. Зээлдэгч өөрийн хүссэнээр дэлгэрэнгүй жагсаалтад нэр нэмж оруулах, эсвэл хасах эрхтэй боловч саналын урилга тараахаас өмнө хураангуй жагсаалтын эцсийн хувилбарыг АХБ-нд явуулж батлуулна. Шаардлагатай бол зээлдэгч ба зөвлөхүүдийн хоорондын хэлэлцээнд АХБ оролцож болох ба зөвлөх ажилтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд нь зээлдэгчид тусалж болно.

Хүчин төгөлдөр бус худалдан авах ажиллагаа

1.18 Холбогдох гэрээ болон энэ журамд заагдсны дагуу сонгон шалгаруулаагүй зөвлөх ажлын зардлыг АХБ санхүүжүүлэхгүй. Сонгон шалгаруулалт тохиролцсон ёсоор хийгдээгүй бол түүнийг АХБ хүчин төгөлдөр бус гэж үзэн ихэнхдээ худалдан авсан ажил үйлчилгээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг хүчингүй болгодог. АХБ хэрэв худалдан авалт хүчин төгөлдөр бус гэж зарласан бол тодорхой хугацааны дараа дахин тендер шалгаруулалт зарлахыг зөвшөөрч болно. Түүнээс гадна АХБ холбогдох гэрээнд заагдсан дутагдлыг арилгуулах бусад арга хэмжээг авах эрхтэй. Хэдийгээр АХБ-наас “татгалзах зүйлгүй” болохоо мэдэгдсний дараа гэрээ байгуулах эрх олгосон ч гэсэн уг “татгалзах зүйлгүй” гэсэн мэдэгдэл нь дутуу, алдаатай, төөрөгдүүлсэн мэдээлэл дээр үндэслэн хийгдсэн эсвэл гэрээний нөхцөлд АХБ-ны зөвшөөрөлгүйгээр их хэмжээний засвар хийгдсэн хэмээн АХБ дүгнэвэл АХБ уг сонгон шалгаруулалтыг хүчин төгөлдөр бус хэмээн зарлах эрхтэй.

АХБ-ыг дурьдах

1.19 Төслийг АХБ-наас бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүжүүлэх тохиолдолд саналын урилга болон гэрээний баримт бичигт АХБ-ыг дараахь байдлаар дурьдана:

“... (Зээлдэгчийн нэр) ... Азийн Хөгжлийн банкны (ердийн хөрөнгийн эх үүсвэр эсвэл Тусгай Сангийн хөрөнгөөс) (төслийн нэр)-ийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор зээл авсан ба энэ зээлийн хөрөнгийг энэ Гэрээний хүрээнд хийгдэх эрх бүхий төлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулагдана. Гэрээ (гэрээнүүд)-ийн нөхцөл, түүний хүрээнд АХБ-наас хийгдэх төлбөр нь бүх талаар зээл/буцалтгүй тусламжийн гэрээ, АХБ ба түүний зээлдэгчид зөвлөх үйлчилгээ авахад баримтлах журам-д захирагдана. АХБ өөрөөр тусгайлан заагаагүй тохиолдолд (зээлдэгчийн нэр)-ээс бусад ямар ч тал зээл/буцалтгүй тусламжийн гэрээнд заасан эрх эдлэх, зээл/буцалтгүй тусламжийн хөрөнгөнөөс нэхэмжлэх эрхгүй.”

Чадавхийг хөгжүүлэх

1.20 АХБ дараахь чиглэлээр чадавхийг бэхжүүлэх туслалцаа үзүүлдэг. Үүнд:

- (i) Тус банкны гишүүн хөгжиж буй орнуудад зөвлөх сонгон шалгаруулах чадавхийг бэхжүүлэх талаар хийх ажил, хэрэгжүүлэх арга замыг боловсруулах хэлбэрээр улс орны зөвлөх сонгон шалгаруулах чадавхийг дээшлүүлж, төслийн өмчлөлийг нэмэгдүүлэх;
- (ii) Зээлдэгчийн зөвлөх сонгон шалгаруулах чадавхид үнэлгээ хийсний үндсэн дээр ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан дадлага давамгайлсан дан эсвэл хосолмол сургалтуудыг явуулснаар зээлдэгчийн зөвлөх авч ажлуулах чадавхийг дээшлүүлэх;
- (iii) Дараахь 4 түвшинд чадавхийг бэхжүүлснээр хөгжиж буй гишүүн орнуудын зөвлөх үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ: (а) бодлогын буюу зохицуулалтын түвшинд энэ салбарын хөгжлийг дэмжсэн бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн төрийн үүргийг дэмжих; (б) зөвлөхүүдийн хамтын байгууллагын түвшинд зөвлөх үйлчилгээний салбарын сургалт явуулах, энэ салбарын эрх ашгийг төлөөлөх чадварыг хөгжүүлэх, (в) зөвлөх компанийн түвшинд жишээлбэл: дотоодын зөвлөх компаниудад “зөвлөх үйлчилгээний менежмент”-ийн арга туршлагаа шилжүүлэх шаардлагыг гадаадын зөвлөх компанийн ажлын даалгаварт оруулах; (г) зөвлөх хувь хүмүүсийн түвшинд зөвлөх үйлчилгээний ажлын боломжуудын талаар мэдээлэл өгөх;

Сургалт явуулах буюу мэдлэг шилжүүлэх

1.21 Хэрэв зөвлөхийн ажил үүрэгт сургалт явуулах, зээлдэгчийн ажилтан, дотоодын зөвлөхүүдэд мэдлэг шилжүүлэх бүрэлдэхүүн хэсэг багтсан бол ажлын даалгаварт

сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, шинж чанар, цар хүрээ, сургагч багш болон сурагчид, ямар ур чадварыг ямар хугацаанд шилжүүлэх, хэрхэн хяналт үнэлгээ хийх талаар нарийн мэдээллийг тусгана. Сургалтын зардлыг ихэвчлэн зөвлөхийн гэрээ ба ажлын төсөвт тусгана.

Хэл

1.22 Зөвлөх үйлчилгээ ашиглах талаар АХБ, зээлдэгч, зөвлөхүүдийн бэлтгэсэн бичиг баримт болон тэдний хоорондын захидал харилцаа нь англи хэл дээр явагдана.

Хуурамчаар мэдүүлэх ба авилгал

1.23 АХБ-ны авилгалын эсрэг баримталдаг бодлого нь зээлдэгчдийг (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шимийг хүртэгчид) төдийгүй зөвлөхүүдийг шалгаруулах болон гэрээ гүйцэтгэх явцдаа ёс зүйн дээд зэргийн хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогод заасны дагуу энэхүү худалдан авах ажиллагааны журмын хүрээнд АХБ:

(а) дор дурьдсан нэр томъёог энэ заалтын хүрээнд дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

- (i) “авилгалын үйл ажиллагаа” гэдэг нь нөгөө талаас хийх үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор ямар нэг үнэ цэнтэй зүйлийг шууд эсвэл шууд бус байдлаар санал болгох, өгөх, авах эсвэл хүсэхийг;
- (ii) “хуурамчаар мэдүүлэх” гэдэг нь санхүүгийн болон бусад ашиг хонжоо олох эсвэл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор ямар нэг талыг санаатай буюу санаандгүй төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;
- (iii) “дарамт, шахалт үзүүлэх” гэдэг нь ямар нэг талын үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор тухайн тал, түүний өмч хөрөнгөд шууд болон шууд бус байдлаар хохирол учруулах, хохирол учруулахаар заналхийлэхийг тус тус хэлнэ.
- (iv) “үгсэн хуйвалдах” гэдэг нь зүй бус зорилгодоо хүрэх түүний дотор нөгөө талын хийх үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоёр буюу эсвэл түүнээс дээш тооны талууд хоорондоо тохиролцоо хийхийг тус тус хэлнэ.

(б) Гэрээ байгуулах эрх олгохыг санал болгосон зөвлөх нь тухайн гэрээг авахаар өрсөлдөж байхдаа шууд, эсвэл төлөөлөгчөөрөө дамжуулан авилгал өгөх, авах, хуурамчаар бүрдүүлэх, үгсэн хуйвалдах, дарамт, шахалт үзүүлэх үйл

ажиллагаа явуулсан болох нь тогтоогдвол тухайн зөвлөхтэй гэрээ байгуулах эрх олгохоос татгалзах эрхтэй.

(в) Зээлдэгч, эсвэл АХБ-ны зээлдэгчийн төлөөлөгч зөвлөх сонгон шалгаруулах, гэрээг байгуулах явцдаа авилгал, хуурамчаар мэдүүлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх үйл ажиллагаа явуулсан бөгөөд зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц ямар нэг зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг хүчингүй болгоно.

(д) Хэрэв тухайн пүүс АХБ-ны санхүүжилттэй гэрээний ажилд өрсөлдөх, гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, хуурамчаар бүрдүүлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх болон бусад хориглосон үйл ажиллагааг шууд болон төлөөлөгчөөрөө дамжуулан явуулсан болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол түүнийг болон түүний залгамжлагчийг тодорхой эсвэл тодорхойгүй хугацаагаар АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагаанд оролцуулахгүй бөгөөд энэ тухайгаа нийтэд зарлана.

(е) АХБ нь зөвлөхүүдийн данс, бүртгэл тооцоо, сонгон шалгаруулалт болон гэрээний гүйцэтгэлтэй холбоотой бусад баримт бичгийг АХБ болон түүний төлөөлөгч үзэж шалгах, АХБ-наас томилсон аудиторoor хянуулахыг зөвшөөрөх заалтыг зөвлөх сонгон шалгаруулах бичиг баримт болон АХБ-наас санхүүжүүлэх гэрээнүүдэд тусгасан байхыг шаардах эрхтэй.

1.24 Үйлчилгээ үзүүлэхээр өрсөлдөх болон үзүүлэх явцдаа саналын урилгад дурьдсан тухайн улс орны залилан, авилгал(түүний дотор хээл хахууль) эсрэг хуулийг дагаж мөрдөх талаар зөвлөхүүдээс баталгаа авах тухай заалтыг АХБ-ны санхүүжилттэй зээлийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төслийн зөвлөх үйлчилгээний саналын урилгад АХБ-ны тусгай зөвшөөрөлтэйгээр зээлдэгч оруулж болно. Уг баталгааг зохицуулах арга зам нь АХБ-ны шаардлагад нийцсэн тохиолдолд зээлдэгч орны хүсэлтээр ийм хэлцэл оруулахыг АХБ зөвшөөрнө.

1.25 АХБ-наас гэрээг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх тохиолдолд саналд заагдснаас өөр ямар ч хураамж, шан, татварын хөнгөлөлт, бэлэг, ашгийн хураамж, эсвэл бусад төлбөрийг зөвлөх сонгон шалгаруулах, гэрээг гүйцэтгэхтэй холбоотойгоор өгөөгүй, аваагүй эсвэл амлаагүй болох талаар зөвлөхийн өгсөн баталгааг гэрээний баримт бичигт багтаасан байна.

Ажлын үнэлгээ

1.26 Зөвлөхийн өмнөх хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл нь түүний цаашдаа энэ чиглэлээр ажиллах боломжийг тодорхойлох ёстой гэж АХБ үздэг. АХБ, түүний зээлдэгчид зөвлөхийн ажилд албан ёсоор үнэлгээ хийдэг бөгөөд энэ үнэлгээний нэг хэсэг болгож тухайн зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөл, зээлийн төсөл, ТТ-г хэрэгжүүлэхэд зээлдэгч болон АХБ-ны чадвар ямар байсан талаар зөвлөхөөс санал авдаг. Мөн зээлдэгч болон АХБ-наас зөвлөхийн ажилд хийсэн үнэлгээний тайланг үзэж танилцах, санал өгөх боломжийг зөвлөхөд олгодог.

Худалдан авах төлөвлөгөө

1.27 Зээл, эсвэл буцалтгүй тусламжийн төсөлд бэлтгэх ажлын нэг хэсэг болгож зээлдэгч нь АХБ-тай зөвшилцсний үндсэн дээр худалдан авах төлөвлөгөө боловсруулна. Уг төлөвлөгөөнд төсөлд шаардлагатай бараа, ажил, зөвлөх үйлчилгээг зээлийн хэлэлцээр хийхээс аль болох өмнө тусгаж бэлтгэнэ. Зөвлөх үйлчилгээний талаар дараахь зүйлийг тусгасан байна: (i) гэрээний багц нэг бүр (ii) санал болгож буй зөвлөх сонгон шалгаруулах арга ба саналын хэлбэр (iii) нийт сонгон шалгаруулалтын урьдчилсан хуваарь, зөвлөх үйлчилгээний гэрээний багц нэг бүрийн төсөвт өртөг. Худалдан авах төлөвлөгөөг зээлдэгч өөрөө бэлтгэснээр зээлдэгчийн өмчлөл нэмэгдэж, зөвлөх үйлчилгээний шаардлагуудыг тодорхойлох, ажлын даалгавар боловсруулах, батлахад зээлдэгчийн оролцоо нэмэгдэж, дотоодын зөвлөхүүдийг тодруулахад илүү анхаарал тавих бололцоо бүрддэг. Зээлдэгч нь шинэ, эсвэл чадавхи султай, гэрээ байгуулахаас өмнө буюу хойно нь товчилсон байдлаар хяналт хийгдэх, эсвэл ТТ-ны төслийг зээлдэгчид хариуцуулахаар төлөвлөсөн байвал худалдан авах төлөвлөгөөг бэлтгэхээс өмнө буюу бэлтгэх явцад зээлдэгчийн уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадварт АХБ үнэлгээ¹³ хийж болно. Энэ үнэлгээнд үндэслэн гэрээ байгуулахаас өмнө буюу хойно хийгдэх хяналтын шаардлага, давтамжийг тодорхойлно. Шаардлагатай бол мөн энэ үнэлгээнд үндэслэн зээлдэгчийн сонгон шалгаруулах чадавхийг бэхжүүлэх сургалт явуулж болно. Хэдийгээр худалдан авах төлөвлөгөөний анхны хувилбарыг төслийн баримт бичиг (RRP)-т оруулах боловч үе үе, шаардлагатай тохиолдолд шинэчилэгдэж байдаг.

¹³ Тухайн орны худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан болон бусад материал, АХБ, бусад олон талт хөгжлийн банкууд тус улс оронд үйл ажиллагаа явуулсан туршлагыг иш үндэс болгоно.

II. ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА

A. Сонгон шалгаруулах аргууд¹⁴

1. Зөвлөх компанийг сонгон шалгаруулах

2.1 Олон төрлийн үйлчилгээ үзүүлэх, журмыг түргэвчлэх, бусад байгууллагуудтай уялдуулах, захиргааны шат дамжлага, зардлыг багасгах үүднээс АХБ сонгон шалгаруулах хэд хэдэн төрлийн арга хэрэглэдэг.

a. Чанар-үнийг харгалзах сонголт (ЧҮХС)

2.2 ЧҮХС нь техникийн саналын чанар ба үзүүлэх үйлчилгээний үнэ өртөгт үндэслэн үнэлгээ өгөх арга юм. ЧҮХС хэрэглэх үед үнэ өртөг нь шалгаруулалтын нэг хүчин зүйл мөн тул энэ аргыг дараахь тохиолдолд ашиглах нь тохиромжтой. Үүнд: (i) хийгдэх ажлын хэмжээг нарийн тодорхойлох боломжтой, (ii) ажлын даалгаврыг нарийн тодорхой заасан, (iii) АХБ, зээлдэгч, зөвлөх нар зөвлөхийг ажиллуулах хугацаа болон зөвлөхийн ажлын бусад орцуудыг боломжийн нарийвчлалтайгаар тооцоолох боломжтой.

- (i) Чанар-үнийг харгалзах сонголтыг зээлийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөлд хэрэглэх нь

2.3 Зээлийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөлд зориулан зөвлөх сонгон шалгаруулахад ЧҮХС-ыг хэрэглэх журмыг дор тайлбарлаж, Хавсралт 1-д хураангуйлан үзүүлэв. Ихэвчлэн зээлдэгч нь АХБ-нд 3 төрлийн материалыг урьдчилсан хяналтад зориулан явуулж зөвшөөрөл авах шаадлагатай байдаг. Үүнд: (i) саналын урилгын төсөл, зөвлөхийн хураангуй жагсаалт, (ii) техникийн саналыг үнэлсэн үнэлгээний тайлан (iii) нийт үнэлгээ ба оноогоор жагсаасан байдал. Сонгон шалгаруулах чадвартай гэдэг нь батлагдсан зээлдэгч (i) саналын урилгын төсөл, зөвлөхийн хураангуй жагсаалт, (ii) нийт үнэлгээ ба оноогоор жагсаасан байдал гэсэн 2 материалыг АХБ-нд явуулж танилцуулна.

a. Ажлын даалгавар боловсруулах

2.4 Зөвлөх компанийг авч ажиллуулахаас өмнө санал болгож буй ажлын зорилго, хэмжээ, зөвлөхийн гүйцэтгэх үүргийг ажлын даалгаварт тодорхой бөгөөд хангалттай зааж өгсөн байна.

б. Зардлын тооцоо (ажлын төсөвт өртөг)

¹⁴ АХБ-ны вэбсайтад тавигдсан www.adb.org “Төслийн удирдлагын зааварчилгаа”-нд сонгон шалгаруулалтын арга тус бүрийг үйлдлээр нь задлан үзүүлсэн болно.

2.5 Зардлыг сайтар тооцоолох нь бодитой төсөв гаргуулж авахад зайлшгүй шаардлагатай. Зээлийн төслийн зөвлөх үйлчилгээний зардлыг зээлдэгч уг үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зүйлүүдэд үндэслэн гаргана. Жишээлбэл: мэргэжилтний ажиллах хугацаа, ложистикийн туслалцаа болон унаа тээвэр, лабораторийн багаж тоног төхөөрөмж зэрэг биет орцууд үүнд багтана. Зардлыг үндсэн хоёр категорид хуваана: (i) цалин хөлс (байгуулсан гэрээнээс хамааран)(ii) урсгал жижиг буюу халаасны зардал. Олон улсын болон дотоодын зөвлөх мэргэжилтний хугацааг бодитой үндэслэлээр тогтооно.

в. Зарлан мэдээлэх

2.6 Ихэвчлэн хураангуй жагсаалт гарахаас өмнө зөвлөх үйлчилгээ шаардлагатай байгаа бүх зээлийн төслүүдийг АХБ-ны вэбсайтад тавьсан байдаг. Үүний зэрэгцээ зөвлөх компаниудын анхаарлыг татаж тэднээс оролцох хүсэлт авах зорилгоор зээлдэгч үндэсний хэмжээний сонин, сэтгүүл, вэбсайтад зар нийтлүүлж болно.

г. Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах

2.7 Зээлдэгч нь оролцох хүсэлтээ ирүүлсэн компаниудаас техникийн чадавхитай зөвлөх компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг гаргана.

д. Зөвлөхүүдийн хураангуй жагсаалтыг гаргах

2.8 Хураангуй жагсаалтыг зээлдэгч гаргана. Оролцох хүсэлтээ ирүүлсэн компаниудаас холбогдох чадавхи бүхий компаниудыг хамгийн түрүүнд харгалзаж үзнэ. Хураангуй жагсаалтад газарзүйн хувьд таран байрласан 6 компанийг оруулах ба нэг улсаас хоёроос дээшгүй, хөгжиж буй орнуудаас наад зах нь нэг компанийг оруулсан байна. Хөгжингүй орнуудаас тийм компани олдохгүй бол жагсаалтад оруулахгүй байж болно. Онцгой нөхцөл байдалд жагсаалтад орсон компаний тоо үүнээс цөөн байхыг АХБ зөвшөөрч болно. Жишээлбэл: Нэг ажлыг гүйцэтгэхээр зөвхөн цөөн тооны чадавхи бүхий компани оролцох хүсэлтээ илэрхийлсэн, эсвэл гэрээний үнийн дүн нь олон өрсөлдөгчийн сонирхол татахааргүй бага хэмжээтэй г.м. Хураангуй жагсаалтад оруулах зорилгоор компаниудын улс орны харьяаллыг тодорхойлохдоо тэдгээрийн бүртгүүлсэн, эсвэл үүсгэн байгуулагдсан улс орон, хэрэв хамтарсан компани бол түүнийг төлөөлж буй компанийн харьяаллаар тодорхойлно. АХБ-наас “татгалзах зүйлгүй” болохоо мэдэгдснээс хойш жагсаалтад нэмэлт, эсвэл хасалт хийж үл болно.

2.9 Хэрэв ажлын үнийн дүн нь АХБ-наас баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан аливаа дээд хязгаар(хязгаарууд)¹⁵-аас бага, эсвэл үнийг өрсөлдөхүйц

¹⁵ Долларын дээд хязгаарыг төслийн шинж чанар, дотоодын зөвлөхүүдийн чадвар, гүйцэтгэх ажлын нарийн төвөгтэй байдлыг харгалзан тогтоож болох ба тухайн улс орон эсвэл зээлдэгчийн худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээний тайланд заасан дээд хязгаараас давж үл болно.

болгохоор хангалттай тооны чадавхи бүхий компани байгаа, эсвэл гадаадын зөвлөхүүд өрсөлдөхгүй гэдэг нь тодорхой, эсвэл гадаадын зөвлөхүүд оролцох сонирхлоо илэрхийлээгүй үед хураангуй жагсаалтыг зөвхөн дотоодын зөвлөхүүдээр, өөрөөр хэлбэл зээлдэгчийн улс оронд бүртгэлтэй буюу тэнд үүсгэн байгуулагдсан зөвлөх компаниудаар бүрдүүлж болно. Салбараар хандах хандлагыг¹⁶ дэмжихэд зориулсан АХБ-ны зээлийн төслүүдэд (засгийн газрын болон/эсвэл хандивлагчид хөрөнгөө нэгтгэдэг) түүнчлэн тэдгээр тоо хэмжээг босго үнэ болгон хэрэглэх ба уг босго үнээс доош хураангуй жагсаалтыг дан ганц дотоодын зөвлөх компаниудаар бүрдүүлж болох ба тэдгээрийг гагцхүү АХБ-тай тохиролцсон журмын дагуу сонгон шалгаруулна. Хэрэв гадаадын компани оролцох хүсэлтээ ирүүлсэн бол түүнийг мөн харгалзаж үзнэ.

е. Саналын урилгыг бэлтгэх, тараах

2.10 Зээлдэгч нь стандарт саналын урилга хэрэглэнэ. Саналын урилгад доорхи зүйлүүдийг багтаасан байна:

- Урилга
- Зөвлөхүүдэд зориулсан зааварчилгаа, тоо баримтын хуудас, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд
- Техникийн саналын стандарт маягт
- Санхүүгийн саналын стандарт маягт
- Ажлын даалгавар
- Гэрээний стандарт маягт
- АХБ-ны гишүүн орнуудын жагсаалт

2.11 Зээлдэгч нь хураангуй жагсаалтад багтсан зөвлөхүүдэд саналын урилга явуулна. Хэрэв АХБ цахим сүлжээ ашиглаж болно гэж үзвэл зээлдэгч цахим сүлжээгээр дамжуулан саналын урилгыг тарааж болно. Цахим систем нь саналын урилгад аливаа өөрчлөлт хийхээс хамгаалагдсан байх ёстой бөгөөд, хураангуй жагсаалтад багтсан зөвлөхүүд саналын урилгыг чөлөөтэй үзэх боломж нээлттэй байна.

ё. Санал хүлээж авах

2.12 Зөвлөх компаниуд техникийн болон санхүүгийн саналыг тус тусад нь дугтуйд хийж битүүмжлэн нэгэн зэрэг ирүүлнэ. Санал хүлээж авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн саналыг задлалгүй буцаана. Эцсийн хугацаанаас хойш техникийн болон санхүүгийн саналд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй.

ж. Техникийн саналыг үнэлэх

¹⁶ Салбараар хандах хандлага гэдэг нь засгийн газрын удирдан хэрэгжүүлэх хөтөлбөрийг дэмжих хандивлагчдын нэг арга бөгөөд хэмжээ нь нэг төслөөс том, ихэвчлэн нэг салбарыг эсвэл салбарын дийлэнх хэсгийг хамарсан байна.

2.13 Зөвлөхүүдэд явуулсан зааварчилгаанд заасан үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийнэ. Техникийн чадавхийг үнэлсний дараа техникийн санал нь нийт 1000 онооноос авбал зохих доод оноо буюу 750 оноо авч чадаагүй компаниудыг шаардлагад нийцээгүй гэж үзэн энэ тухай мэдэгдэх ба санхүүгийн саналыг нь нээлгүй буцаана. Техникийн саналд авбал зохих доод оноо болон түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдэд санхүүгийн саналыг нээх газар, өдөр, хугацааг мэдэгдэнэ.

з. Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх

2.14 Техникийн саналд 750 буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдэд санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх газар, өдөр, хугацааг мэдэгдэнэ. Санхүүгийн саналыг нээмэгц компаниудын нэр, техникийн саналд авсан оноо, санал болгож буй үнийг зарлаж тэмдэглэл хөтөлнө.

и. Санхүүгийн саналыг үнэлэх

2.15 Зээлдэгч дээрх үйлдлүүдийн дараа техникийн болон санхүүгийн санал хоорондоо тохирч байгаа эсэхийг шалгаж арифметикийн болон тооцооны алдааг залруулж шаардлагатай тохируулга хийнэ.

к. Саналуудыг эрэмблэх

2.16 Техникийн болон санхүүгийн саналын онооны хувийн жинг хооронд нь нэмж гаргасан нийт оноог үндэслэн саналуудыг эрэмбэлнэ. Техникийн саналын чанар нийт үнэлгээний 80%, үнийн санал 20% - ийг тус тус бүрдүүлнэ.

л. Хэлэлцээ хийх

2.17 Зээлдэгч хамгийн өндөр оноо авсан зөвлөх компанитай хэлэлцээ хийж ажлын даалгавар, арга зүй, мэргэжилтнүүдийн хуваарь, зээлдэгчийн материаллаг бааз болон компаний санхүүгийн саналд тусгасан зардлуудын тоо хэмжээг ярилцана. Гэхдээ хэлэлцээгээр урилгад хавсаргасан ажлын даалгаварт их хэмжээний засвар оруулж болохгүй. Сонгон шалгаруулах явц удаан хугацаагаар саатсан¹⁷ нь мэргэжилтнүүдийг солихоос аргагүйд хүргэсэн, эсвэл ажлын эцсийн зорилгыг биелүүлэхэд тийнхүү солих зайлшгүй шаардлагатай гэж хоёр тал үзсэнээс бусад тохиолдолд шалгарсан зөвлөх компани мэргэжилтнүүдээ сольж болохгүй. Нэгж үнэ нь сонгон шалгаруулах явцад харгалзаж үзсэн хүчин зүйлүүдийн нэг тул санал болгосон цалин хөлсний нэгж үнийг өөрчилж үл болох ба бусад зардлыг ч хэлэлцэж болохгүй. Хэлэлцээ амжилттай болбол гэрээнд гарын үсэг зурна. Санхүүгийн хэлэлцээний явцад зөвлөхийн зээлдэгчийн улс оронд төлөх татвар (хэрэв байгаа бол), энэ татварыг гэрээнд хэрхэн тусгасан, эсвэл тусгах талаар хэлэлцэнэ. Хэрэв зээлдэгч, зөвлөх компани нар тохиролцоонд хүрч чадахгүй бол зээлдэгч АХБ-ны зөвшөөрөлтэйгээр хэлэлцээг зогсоож удаахь өндөр оноо авсан

¹⁷ Саналын урилгад саналын хүчинтэй байх хугацааг бодитой тусгаж үр ашигтай үнэлгээ хийснээр энэ төрлийн эрсдлийг багасгаж болно.

компанитай тохиролцоонд хүртлээ хэлэлцээ хийнэ. Зээлдэгч гарын үсэг зурсан гэрээний хувийг АХБ руу явуулна.

м. Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх

2.18 Гэрээ байгуулах эрх олгосны дараа зээлдэгч дараахь мэдээллийг АХБ-ны вэбсайтад¹⁸ тавиулахаар явуулна. Үүнд: (i) санал ирүүлсэн бүх зөвлөхүүдийн нэр, (ii) зөвлөхүүдийн техникийн саналд өгсөн оноо, (iii) зөвлөхүүдэд өгсөн нийт оноо, (iv) шалгарсан зөвлөхийн нэр, гэрээний үнийн дүн.

н. Тайлбар хүсэх

2.19 Аль ч зөвлөх саналаас нь ямар үндэслэлээр татгалзсан болохыг тогтоохыг хүсвэл зээлдэгчээс тайлбар хүсэх эрхтэй гэдгийг гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдээлэлд дурьдана. Зээлдэгч ямар учраас тухайн зөвлөхийн саналыг сонгоогүй тухай тайлбарыг шуурхай өгнө.

о. Бүх саналаас татгалзах ба шинээр урилга явуулах

2.20 Зөвхөн бүх санал ажлын даалгавраас их хэмжээгээр зөрсөн, эсвэл бүх саналын үнэ нь анх тооцсон төсөвт өртгөөс нилээд хэмжээгээр хэтэрсэн бол тэдгээрийг шаардлагад нийцээгүй гэж үзэн бүх саналаас татгалзах шийдвэрийг зээлдэгч гаргаж болно. Үнэ хэтэрсэнтэй холбогдох хоёр дахь тохиолдолд төсөвт өртгийг өсгөх эсвэл тухайн зөвлөх компаниас үзүүлэх үйлчилгээний хэмжээг бууруулах бололцоотой эсэхийг АХБ-тай зөвшилцөн судалж үзнэ. Зээлдэгч бүх саналаас татгалзаж шинээр урилга явуулахаас өмнө АХБ-нд ингэх болсон шалтгаанаа тайлбарлаж АХБ-ны “татгалзах зүйлгүй” эсэхийг нь лавлана. Шинээр урилга тараахын өмнө саналын урилга (хураангуй жагсаалтыг оролцуулан) болон төсөвт өртөгт өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлтийг хийхдээ АХБ-наас зөвшөөрөл авсан байна.

п. Нууцлал

2.21 2.14, 2.16 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдээ нийтлэгдэх хүртэл саналуудыг үнэлсэн байдал, гэрээ байгуулах эрх олгох саналтай холбоотой аливаа мэдээллийг санал ирүүлсэн зөвлөхүүд болон шалгаруулах үйл ажиллагаатай албан ёсоор холбоогүй хүмүүст мэдээлэхийг хориглоно.

(ii) Чанар-үнийг харгалзах сонголтыг ТТ-ны төсөлд хэрэглэх нь

2.22 Чанар-үнэд үндэслэсэн шалгаруулалтыг ТТ-ны төсөлд хэрэглэх журам нь зээлийн болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ний төслийнхтэй төстэй бөгөөд Хавсралт 1-д товчлон харуулав.

б. Чанарыг харгалзах сонголт (ЧХС)

¹⁸ www.adb.org

2.23 Чанарыг харгалзсан сонголт (ЧХС) нь зөвхөн техникийн саналын чанарт үнэлгээ хийж техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхтэй санхүүгийн болон гэрээний нөхцлийн талаар хэлэлцээ хийхийг хэлнэ. ЧХС нь дараахь нөхцөлд тохиромжтой. Үүнд: (i) Ажил нь нарийн төвөгтэй цогцолбор, эсвэл нарийн мэргэжлийн ур чадвар шаардах ажлын даалгаврыг агуулсаны улмаас, зөвлөхүүдээс авах үйлчилгээг нарийн тодорхойлоход хүндрэлтэй, (ii) Ажлын явцын үр ашиг, үйлчилгээний чанар нь төслийн эцсийн үр дүнд хамгийн чухал нөлөө үзүүлэх (iii) Ажлыг өөр хэд хэдэн аргаар гүйцэтгэж болох учраас санхүүгийн саналыг харьцуулах боломжгүй.

(i) Зээл болон зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төсөлд ЧХС-ыг хэрэглэх нь

2.24 Ерөнхийдөө ЧХС-ыг хэрэглэх үед үнэ шалгуур үзүүлэлт болохгүй тул саналын урилгад зөвхөн техникийн санал ирүүлэхийг хүснэ. Зээлдэгч нь зөвлөхүүдийн техникийн саналыг үнэлэх, эрэмбэлэхдээ ЧҮХС-тай ижил арга зүйг ашиглах ба техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөс санхүүгийн нарийвчилсан санал, бусад дагалдах материалын хамт ирүүлэхийг хүснэ. Зөвлөхийн ирүүлсэн санхүүгийн материалд аудит хийж болно. Үүний дараа зээлдэгч, зөвлөх нар санхүүгийн санал болон гэрээний талаар хэлэлцээ хийнэ. Сонгон шалгаруулалтын бусад бүх үйл явц нь ЧХС-той яг адил байна. Харин гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдээлэлд зөвхөн шалгарсан зөвлөх компаний санал болгосон үнийг нийтэлнэ. ЧХС-ыг хэрэглэх үед бүх зээлдэгч дараахь хоёр материалыг (өмнөх хяналт) АХБ-нд явуулж зөвшөөрөл авна. Үүнд: (i) хураангуй жагсаалт (ii) эцсийн үнэлгээ. Журмыг Хавсралт 1-д хураангуйлан үзүүлэв.

(ii) ТТ-ны төсөлд ЧХС-ыг хэрэглэх нь

2.25. Чанарыг харгалзах сонголтыг ТТ-ны төсөлд хэрэглэх журам нь зээл, зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төслийнхтэй төстэй бөгөөд Хавсралт 1-д хураангуйлан үзүүлэв.

в. Батлагдсан төсвийг харгалзах сонголт (БТХС)

2.26 Зөвхөн дараахь нөхцөлд БТХС-ыг хэрэглэх нь тохиромжтой. Үүнд: (i) Ажлын даалгаврыг нарийвчлан тодорхойлсон (ii) хугацаа, мэргэжилтнүүдийн орцыг нарийн тодорхойж болох (iii) тогтсон төсөвт өртөгтэй бөгөөд түүнийг нь өөрчлөх боломжгүй. Зөвлөхүүдэд учирч болох эрсдлүүдийг багасгах, шаардлага хангаагүй техникийн санал хүлээн авах, эсвэл огт санал хүлээж авахгүй байхаас урьдчилан сэргийлэхийн тулд энэ аргыг зөвхөн хэрэгжүүлэх явцад нь ямар ч өөрчлөлт гарахгүй нарийн боловсруулсан ТТ-ны төсөлд хэрэглэж болно. БТХС-ын хураангуй жагсаалтад ихэвчлэн газар зүйн хувьд харьцангуй таран байрласан зургаан зөвлөх компанийг багтаана. Саналын урилгад төсөвт өртгийн үнэ, “чанарын үзүүлэлт”-ээр авбал зохих доод оноо нь нийт 1000 онооноос 750

байх тухай танилцуулж, компаниудыг хамгийн сайн техникийн болон санхүүгийн саналаа заасан төсөвт өртөгт багтаан тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж нэгэн зэрэг ирүүлэхийг хүснэ. Эхлээд техникийн саналуудад үнэлгээ өгнө. “Чанарын үзүүлэлт”-ээр авбал зохих доод оноо, эсвэл түүнээс дээш оноо авсан компаниудын санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнийг зарлана. Заасан төсөвт өртгөөс хэтэрсэн саналыг хасна. Үлдсэн саналуудаас техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийг шалгаруулж хэлэлцээ хийнэ. Хэлэлцээ амжилтгүй болбол АХБ удаах өндөр оноо авсан зөвлөх компанитай тохиролцоонд хүртлээ хэлэлцээ хийнэ.

г. Бага үнийг харгалзах сонголт (БҮХС)

2.27 Аудит, инженерийн зураг төсөл, энгийн төслийг хянах, энгийн хэмжилт хийх зэрэг тогтсон арга зүй, стандарт баримталдаг, хэвшсэн, стандарт үйл ажиллагаатай маш жижиг¹⁹ хэмжээний ажилд бага үнийг харгалзах сонголтыг хэрэглэх нь тохиромжтой. БҮХС-ыг хэрэглэх сонгон шалгаруулалтын хураангуй жагсаалт нь ихэвчлэн газар зүйн хувьд таран байрласан гурван компаниас бүрдэнэ. Саналын урилгад “чанарын үзүүлэлт”-ээр авбал зохих доод оноо нь нийт 1000 онооноос 750 оноо байх тухай дурьдаж компаниудыг техникийн болон санхүүгийн саналаа тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж нэгэн зэрэг ирүүлэхийг хүснэ. Техникийн саналыг эхэлж нээн үнэлгээ өгнө. Авбал зохих доод онооноос бага оноо авсан компанийг хасч үлдсэн компаниудын санхүүгийн саналыг нийтийн өмнө нээнэ. Хамгийн бага үнэ санал болгосон зөвлөхийг шалгаруулж гэрээг эцсийн байдлаар тохирохыг хүснэ. Хэлэлцээ амжилтгүй болбол зээлдэгч, эсвэл АХБ удаах бага үнэ санал болгосон компанитай тохиролцоонд хүртэл хэлэлцээ хийнэ.

д. Зөвлөхийн ур чадварыг харгалзах сонголт (ЗУЧХС)

2.28 Энэ аргыг дараахь нөхцөлд жижиг хэмжээний²⁰ ажил гүйцэтгүүлэхэд ашиглахад тохиромжтой. Үүнд: (i) ажил нь нарийн мэргэжлийн мэдлэг чадвар шаардсан, тодорхой нэг салбараар гүнзгий судалгаа хийдэг “*бутук*” зөвлөх компаниудыг авч ажлуулахаар тооцоолсон (ii) авч ажлуулах цаг хугацаа нь чухал бөгөөд ихэвчлэн богино хугацаатай (iii) энэ чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийн тоо цөөн (iv) илүү өрсөлдөөнтэй санал ирүүлэх, үнэлэх үндэслэлгүй. АХБ эсвэл зээлдэгч (i) ажлын даалгавар бэлтгэн (ii) дэлгэрэнгүй оролцох хүсэлт болон зөвлөхүүдийн тухайн төрлийн ажлыг урьд өмнө нь гүйцэтгэж байсан туршлага, энэ талын чадварын талаар мэдээлэл ирүүлэхийг хүсч (iii) гурваас доошгүй зөвлөх компаниас бүрдсэн хураангуй жагсаалт гарган (iv) оролцох хүсэлтүүдээс хамгийн сайн чадвар, тодорхойлолттой компанийг сонгоно. Шалгарсан компанийг техникийн болон санхүүгийн нэгтгэсэн саналаа ирүүлэхийг хүссэний дараа гэрээний хэлэлцээнд урина.

¹⁹ Ихэвчлэн 100,000 ам доллараас бага

²⁰ Ихэвчлэн 200,000 ам доллараас бага

Хэлэлцээ амжилтгүй болбол удаахь сайн чадвартай компанитай тохиролцоонд хүртэл хэлэлцээ хийнэ.

е. Нэг эх үүсвэрийн арга (НЭҮА)

2.29 Зөвлөхүүдийг ганц эх үүсвэрээс сонгон шалгаруулах нь чанар, үнийн өрсөлдөөний ач холбогдолгүй, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг алдагдуулдаг бөгөөд зохисгүй үйл ажиллагааг дэвэргэж болзошгүй. Иймд энэ аргыг зөвхөн онцгой тохиолдолд л хэрэглэх нь зүйтэй. НЭҮА-ыг хэрэглэх үндэслэлийг захиалагч болон төслийн нийт эрх ашиг, хэмнэлттэй, үр ашигтай байх, бүх чадавхи бүхий зөвлөхүүдэд эрх тэгш боломж олгох гэсэн АХБ-ны зарчмыг харгалзан хянаж үзнэ.

2.30 НЭҮА-ыг хэрэглэх нь өрсөлдөөнөөс илт давуу талтай: (а) тухайн ажил нь уг компанийн өмнө нь хийж гүйцэтгэсэн ажлын үргэлжлэл болох (дараагийн зүйлийг үз), (б) гамшиг зэрэг онц яаралтай тохиолдол бүрэлдсэн, (в) маш жижиг хэмжээний²¹ ажилд эсвэл, (г) ажлыг гүйцэтгэх чадвартай, эсвэл энэ чиглэлийн онцгой туршлагатай зөвхөн ганц компани байгаа үед.

2.31 Ажлын залгамж чанарыг хангах зайлшгүй шаардлагатай бол анх саналын урилга гаргахдаа төслийн энэ хэтийн төлвийг дурьдаж, хэрэв боломжтой бол сонгон шалгаруулах хүчин зүйлүүдийг боловсруулахдаа цаашид үргэлжлэх төлөвтэй ажил гэдгийг харгалзаж үзнэ. Техникийн арга замын залгамж чанарыг хадгалах, энэ чиглэлээр туршлага хуримтлуулсан, үргэлжлүүлэн мэргэжлийн хариуцлага хүлээх чадвартай бөгөөд эхний ажлыг хангалттай сайн гүйцэтгэсэн бол анхны зөвлөхийг үргэлжлүүлэн ажлуулах нь шинээр өрсөлдөөнт шалгаруулалт зарласнаас давуу талтай байж болно. Ийм үргэлжлэх ажлын зөвлөхийг сонгохдоо зээлдэгч нь анх шалгарсан зөвлөхөөс зээлдэгчийн боловсруулсан ажлын даалгаварт нийцүүлэн техникийн болон санхүүгийн санал бэлтгэхийг хүсч ирүүлсэн саналаар хэлэлцээ хийнэ. Хэрэв анхны ажлын зөвлөхийг өрсөлдөөнт аргаар шалгаруулаагүй, үргэлжлэх ажил нь өмнөхөөсөө нилээд их хэмжээтэй байвал ихэвчлэн АХБ-ны шаардлага хангасан өрсөлдөөнт шалгаруулалтыг явуулна. Хэрэв анхны ажлыг гүйцэтгэсэн зөвлөх оролцох сонирхлоо ирүүлбэл түүнийг мөн оруулж болно. Зөвхөн онцгой нөхцөл байдалд, эсвэл шинээр өрсөлдөөнт шалгаруулалт явуулах боломжгүй бол АХБ энэ дүрмээс гажихыг зөвшөөрнө.

²¹ “Маш жижиг” гэсэн босго үнийн доллараар илэрхийлэгдсэн хэмжээг тухайн нөхцлөөс хамааран тогтоох бөгөөд ажлын шинж чанар, нарийн төвөгтэй байдлыг харгалзан үзэх боловч 100,000 ам доллараас хэтрэхгүй байна.

2.32 Зээлдэгч, эсвэл АХБ НЭҮА хэрэглэхийг санал болговол АХБ-ны ажлын хэсэг энэ журмыг ТТ-ны төслийн баримт бичиг, зээлийн төслийн баримт бичиг (RRP)-т тусгана. Зээлдэгч, эсвэл АХБ зөвлөхүүдийн анкет бүхий техникийн санал (АТС)²²-ыг санхүүгийн саналын хамт нэгэн зэрэг ирүүлэхийг зөвлөхөөс хүснэ. АХБ, эсвэл зээлдэгч АТС-ийн хангалттай эсэхийг хянаж тухайн компани, эсвэл хувь хүнтэй гэрээ байгуулна.

ё. Арилжааны арга (АА)

2.33 Санхүүгийн зуучаар дамжуулан хувийн хэвшилд, эсвэл арилжааны хувьд биеэ даасан төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газруудад дамжуулан зээлдүүлсэн зээлийн төслүүдэд зөвлөх шалгаруулахдаа дамжуулан зээлдэгч нь хувийн хэвшил, эсвэл арилжааны үйл ажиллагаанд тогтсон аргыг АХБ-наас зөвшөөрсөн тохиолдолд хэрэглэж болно. Мөн өмнө өгүүлсэн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргыг ялангуяа том хэмжээний зөвлөх үйлчилгээнд хэрэглэж болно.

2. Зөвлөх хувь хүнийг сонгох

2.34 Зарим төрлийн зөвлөх үйлчилгээнд хувь хүнийг сонгох нь компани сонгосноос илүү тохиромжтой, зардал хэмнэх сайн талтай байдаг. Зээлдэгч, эсвэл АХБ зөвлөх хувь хүмүүсийг шууд (бие даасан зөвлөх хувь хүн), эсвэл зөвлөх компани, эрдэм шинжилгээний байгууллага, засгийн газар, олон улсын байгууллага зэрэг байгууллагаар дамжуулан авч ажиллуулж болно. Сонгон шалгаруулах журам нь олон улсын болон дотоодын зөвлөх компани шалгаруулахаас хялбар байдаг. Зөвлөх хувь хүнийг сонгох үндэслэл нь ажлыг гүйцэтгэх чадвар байна. Зээлдэгч зээлийн төсөлд олон улсын болон дотоодын зөвлөх үйлчилгээ ашиглах бол зээлийн хэлэлцээ хийгдэхээс аль болох өмнө (i) ажилд хамгийн их тохирох зөвлөх (ii) сонгон шалгаруулахад хэрэглэх журмын талаар АХБ-тай зөвшилцөлд хүрсэн байна. Ихэнхдээ зээлдэгч тэдгээр зөвлөхүүдийг АХБ-ны шаардлага хангахуйц засгийн газрын журмын дагуу сонгон шалгаруулна. ТТ-ны төсөл дээр зөвлөх хувь хүн шалгаруулах журам нь ажлын даалгаврын нарийн төвөгтэй байдал²³ ба ажлын үргэлжлэх хугацаанаас хамаарна.

3. Тусгай зөвлөх сонгон шалгаруулах

а. Ажилтан зөвлөх

2.35 АХБ ажилтан зөвлөхөд тавигдах шаардлагыг тодорхойлж, ажлын даалгаврыг боловсруулна. АХБ ирүүлсэн оролцох хүсэлтүүд болон зөвлөх хувь хүмүүсийн тухай мэдээлэл (ЗХХТМ) дээр үндэслэн тохирох нэр дэвшигчийг тодруулна. Шаардлагатай бол байгууллага, зөвлөх компаниудаас нэр ирүүлэхийг хүснэ.

²² АТС нь ажлын төлөвлөгөө, мэргэжилтнүүдийн хуваарь, санал болгож буй бүх зөвлөхийн анкетаас бүрдэнэ.

²³ Энэ тохиолдолд нарийн төвөгтэй байдал гэдэг нь “ажлын түвшин” (ажлын үүрэг хариуцлага, шаардлагатай чадавхи, зөвлөхийн ажлын туршлага дээр үндэслэх)-ээр тодорхойлогдоно.

б. Нөөцийн хүн

2.36 Нөөцийн хүнийг 10 ажлын өдрөөс дээш хугацаагаар ажиллуулж болохгүй. Гэхдээ нэг эх үүсвэрээс сонгон шалгаруулах аргыг хэрэглэж болно.

в. НҮБ болон бусад мэргэшсэн байгууллагууд

2.37 Өөрсдийн мэргэшсэн чиглэлээр техник туслалцаа, зөвлөгөө өгөх чадвартай бол НҮБ болон бусад ижил төстэй байгууллагуудыг зөвлөхөөр авч ажлуулж болно. Мөрдөгдөж буй олон улсын гэрээ конвенцийн дагуу НҮБ-ын системийн байгууллагууд, түүний ажилтнуудын тусгай эрх ямба, халдашгүй дархан байдлыг зээлдэгч хүлээн зөвшөөрч, тус байгууллагын дүрэм ёсоор тусгай хөлс төлөхөөр зөвшөөрсөн бөгөөд АХБ-наас энэ тохиролцоог хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд өрсөлдөөнт шалгаруулалтын явцад эдгээр байгууллагуудад давуу эрх олгохгүй. НҮБ-ын системийн байгууллагуудын тусгай эрх ямба, татвараас чөлөөлөгддөг, материаллаг бааз сайтай зэрэг давуу талууд, тусгай хөлс төлөх заалт зэргийг саармагжуулахын тулд ЧА-ыг хэрэглэнэ. Энэхүү журмын 2.29 дүгээр зүйлд заасан болзол хангагдвал НҮБ-ын системийн байгууллагуудыг нэг эх үүсвэрийн аргаар шалгаруулсны үндсэн дээр хөлсөлж болно.

г. Төрийн бус байгууллагууд (ТББ)

2.38 АХБ үйл ажиллагааныхаа үр ашигтай байдал, чанар, тогтвортой байдлыг хангах үүднээс өргөн хүрээний олон улсын болон үндэсний ТББ-уудтай хамтарч ажилладаг. Хэрэв АХБ, зээлдэгч нар том хэмжээний олон улсын ТББ-ын чадварыг хангалттай гэж үзвэл тэдгээрийг ТТ, зээлийн төслийн зөвлөхийн хураангуй жагсаалтад оруулж болно. Жижиг хэмжээний (ялангуяа үндэсний) ТББ-уудыг авахдаа хялбаршуулсан сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журам хэрэглэнэ. Олон улсын ТББ зөвлөх компаниудтай зэрэгцэн ТТ, зээлийн төслийн зөвлөхийн хураангуй жагсаалтад багтсан тохиолдолд ЧА-ыг хэрэглэнэ. ТТ, зээлийн төсөл нь орон нутгийн асуудал, нутгийн иргэдийн хэрэгцээний талаар гүнзгий мэдлэг болон/эсвэл оролцооны арга шаардсан бөгөөд олон улсын эсвэл үндэсний ТББ илт давуу чадавхитай байвал хураангуй жагсаалтыг дан ганц ТББ-уудаар бүрдүүлж болох ба ЧҮА-ыг хэрэглэнэ. ТТ, зээлийн төслийн хүрээнд үндэсний ТББ-ыг ажиллуулах тохиолдолд АХБ хялбаршуулсан ЧҮА-ыг хэрэглэж болно. Энэ нь өрсөлдөгч ТББ-уудын чадавхийг харуулах зорилготой бөгөөд үнэлгээний шалгуур үзүүлэлт нь (i) өмнө нь орон нутгийн хүмүүстэй ажиллаж байсан туршлага, ажлаа хангалттай сайн гүйцэтгэснийг нотлох нотолгоо, (ii) хөгжлийн оролцооны аргыг мэддэг эсэх, (iii) манлайлах чадвар, менежмент сайтай эсэх, (iv) төслийн үр шимийг хүртэгчдийг татан оролцуулах чадвар зэрэг ТББ-уудын онцгой чадваруудыг тусгасан байна. Энэхүү журмын 2.29 дүгээр зүйлд заасан нөхцөл бүрдвэл АХБ, эсвэл зээлдэгч ТББ-ыг нэг эх үүсвэрийн аргаар шалгаруулж болно.

д. Худалдан авах ажлын төлөөлөгч (ХААТ)

2.39 Зээлдэгчийн зохион байгуулалтын чадвар, хүн хүч, хөрөнгийн нөөц, туршлага дутагдалтай үед худалдан авах ажилд мэргэшсэн компанийг өөрийн төлөөлөгчөөр сонгох нь үр ашигтай, үр дүнтэй байж болно. Тодорхой бараа, материал худалдан авах ажилд ХААТ-ийг хөлсөлсөн бөгөөд тэр нь ерөнхийдөө өөрийн ажлын байрнаас ажлаа явуулдаг бол зохион байгуулсан худалдан авах ажлын үнийн дүнгийн тодорхой хувиар, эсвэл тодорхой хувь ба тогтмол хөлсний нийлбэрээр цалинжуулна. Энэ тохиолдолд ХААТ-ийг ЧҮА-аар сонгох ба нийт онооны 50% хүртэл хувийг үнийн санал бүрдүүлнэ. ХААТ нь худалдан авах ажиллагаанд зөвхөн зөвлөх үүрэг гүйцэтгэх, эсвэл төслийг нийтэд нь хариуцсан “төлөөлөгч”-өөр төслийн тусгай зориулалтын ажлын байранд ажиллах бол тэдний хөлсийг ихэвчлэн цагаар тооцно. Энэ тохиолдолд ХААТ-ийг ЧҮА-аар сонгож энэхүү журамд заасан цагийн гэрээ хийнэ. Төлөөлөгч зээлдэгчийн нэрийн өмнөөс зээлийн гэрээ болон АХБ-наас баталсан худалдан авах төлөвлөгөөнд заасан бүхий л худалдан авалт, түүний дотор саналын урилга хэрэглэх, АХБ-аар хянуулах, бичиг баримт бүрдүүлэх журмыг мөрдөнө.

е. Хянан шалгах төлөөлөгч

2.40 Зээлдэгч бараа материалыг ачуулах эсвэл зээлдэгчийн улс оронд ирэхээс өмнө шалгаж баталгаажуулах зорилгоор хянан шалгах төлөөлөгч хөлсөлж болно. Ийм төлөөлөгч нь ихэвчлэн тухайн барааны чанар, тоо хэмжээ, үнийн бодитой байдлыг шалгах үүрэг гүйцэтгэдэг. Хянан шалгах төлөөлөгчийг ЧҮА-аар сонгох бөгөөд нийт үнэлгээний 50% хүртэл хувийг үнийн санал бүрдүүлнэ. Шалгаж баталгаажуулсан барааны үнийн дүнгээр төлбөр төлөх гэрээ байгуулна.

ё. Банк

2.41 Өмч хөрөнгө худалдах, үнэт цаас гаргах, байгууллагын бусад санхүүгийн хэлцэл хийх, ялангуяа өмч хувьчлалын үйл ажиллагаанд туслалцуулахаар зээлдэгчийн хөлслөх хөрөнгө оруулалтын ба арилжааны банкууд, санхүүгийн пүүсүүд, сангийн менежерүүдийг ЧҮА-аар сонгоно. Саналын урилгад ижил төстэй ажил гүйцэтгэж байсан эсэх, боломжит худалдан авагчдын сүлжээтэй эсэх зэрэг тухайн үйл ажиллагаатай холбогдолтой болон үйлчилгээний үнэтэй холбогдолтой шалгуур үзүүлэлтүүд заасан байна. Ердийн хөлс (“тогтмол хөлс” гэх)-нөөс гадна “амжилтын хөлс” төлж болох ба энэ нь тогтмол байж болох боловч ихэвчлэн зарагдах өмч, эсвэл үнэт цаасны үнийн дүнгийн хувиар илэрхийлэгддэг. Үнийн саналыг үнэлэхдээ амжилтын хөлсийг тогтмол хөлсний хамт хослуулан, эсвэл дангаар нь харгалзаж үзэх тухай саналын урилгад заана. Хэрэв амжилтын хөлсийг дангаар нь харгалзаж үзэх бол хураангуй жагсаалтад багтсан бүх зөвлөхүүдэд стандарт тогтмол хөлс тогтоох ба энэ тухай саналын урилгад зааж санхүүгийн саналыг амжилтын хөлсөнд үндэслэн үнэлнэ. Хосолмол үнэлгээ хийх бол (ихэвчлэн том хэмжээний гэрээнд) нийт онооны үнийн саналд эзлэх хувийг 2.16 дугаар зүйлд санал болгосноос өндөр хувиар

тогтоож болно. Эсвэл саналын чанарын авбал зохих доод буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдийг дан ганц үнийн саналаар шалгаруулж болно. Саналын урилгад саналуудыг хэрхэн бэлтгэх, тэдгээрийг яаж харьцуулах талаар тусгана.

ж. Аудитор

2.42 Аудиторууд нь ихэвчлэн нарийн тодорхойлсон ажлын даалгавар, мэргэжлийн стандартын дагуу аудит хийдэг. Тэднийг нийт онооны 50 хүртэл хувийг үнийн санал бүрдүүлэх ЧҮА-аар эсвэл 2.27 дугаар зүйлд заасан бага үнийн аргаар шалгаруулна. Маш жижиг хэмжээний²⁴ ажилд ЗЧА-ыг хэрэглэж болно.

з. Үйлчилгээ үзүүлэх ажил

2.43 Сургалт, төслийн сургалтын материал боловсруулах, бэлтгэх, суртчилгааны материал, видео бичлэг хийх, семинарт бэлтгэх, зохион байгуулах зэрэг туслах үйлчилгээ шаардсан төслүүд дээр тийм үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, мэргэжлийн байгууллагуудыг гэрээний үндсэн дээр ажлуулж болно. Ажлын даалгавар бэлтгэж 2.48 дугаар зүйлд заасан үйлчилгээ үзүүлэгчтэй бөөнд нь төлөх гэрээ байгуулах нь хамгийн тохиромжтой арга мөн.

Б. Гэрээний төрлүүд

2.44 Гэрээний аль төрлийг сонгох нь (i) ажлын шинж чанар, (ii) ажлын хэмжээ, үр дүнг хэмжих боломжтой эсэх (iii) эрсдлийг холбогдох талууд хуваан хариуцах эсэх зэргээс шалтгаална.

1. Хугацааны гэрээ²⁵

2.45 Тухайн үйлчилгээ нь бусдын эрхэлж буй, дуусах хугацаа нь янз бүр өөр ажил, үйлчилгээнээс хамааралтай тэдгээрийн дуусах хугацаанаас шалтгаалах, эсвэл зөвлөхийн ажлын орцыг тодорхойлох нь хүндрэлтэйн улмаас үйлчилгээний цар хүрээ, үр дүн, үргэлжлэх хугацааг тодорхойлоход бэрхшээлтэй үед хугацааны гэрээг хэрэглэдэг. Энэ төрлийн гэрээг цогцолбор судалгаа, барилгын ажлын хяналт, зөвлөгөө өгөх болон ихэнх сургалтад ашигладаг. Гэрээний төлбөрийг зөвлөхийн орцоос хамааран ихэвчлэн гэрээнд заасан мэргэжилтний сарын хөлс, гарсан бодит зардал, эсвэл тохиролцсон нэгж хөлсөнд үндэслэн тооцдог.

2. Тогтмол хөлс ба магадлашгүй ажлын хөлсний (үр дүнгийн) гэрээ

2.46 Зөвлөхүүд (банк, санхүүгийн пүүс) компаниудыг худалдах, нэгтгэх, ялангуяа өмч хувьчлалын үйл ажиллагаанд оролцож байгаа үед тогтмол болон магадлашгүй ажлын

²⁴ 21 дүгээр зүүлтийг үз.

²⁵ Заримдаа явцын төлбөрийн гэрээ гэж нэрлэгдэх нь бий.

хөлсний гэрээг түгээмэл хэрэглэдэг. Зөвлөхийн цалин хөлсөнд тогтмол хөлс ба үр дүнгээс хамаарсан хөлс багтсан байна. Үр дүнгээс хамаарсан хөлсийг ихэвчлэн худалдсан өмчийн үнийн дүнгийн тодорхой хувиар тооцдог.

3. Товлогдоогүй хугацаанд үйлчилгээ үзүүлэх гэрээ (Үнийн гэрээ)

2.47 Энэ гэрээг зээлдэгчид хэмжээ, тов нь урьдчилан тодорхойлоход төвөгтэй ямар нэг үйл ажилд “дуудлагаар” зөвлөгөө авах тусгай үйлчилгээ шаардлагатай тохиолдолд хэрэглэнэ. Энэ нь ихэвчлэн цогцолбор төсөл (далан барих гм) хэрэгжүүлэхэд “зөвлөхүүд”-ийг, маргаан таслах зөвлөлд мэргэжлийн шүүгчийг, бүтцийн өөрчлөлт, худалдан авах ажиллагааны зөвлөгөө өгөх, техникийн эвдрэл олох зэрэгт зөвлөхүүдийг жил, түүнээс дээш хугацаагаар тус тус бэлэн байлгахад ашигладаг. Зээлдэгч ба зөвлөх компани нар нэгж ажлын хөлсийг тохиролцох ба төлбөрийг зарцуулсан бодит хугацаанд үндэслэн олгодог.

4. Бөөнд нь төлөх гэрээ (БТГ)

2.48 Бөөнд нь төлөх гэрээг зөвлөхийн ажлын агуулга, үргэлжлэх хугацаа, гарах үр дүн нь тодорхой үед байгуулна. Үүнд энгийн төлөвлөх, техник эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны судалгаа, стандарт түгээмэл бүтцийн нарийвчилсан зураг төсөл, үйлчилгээ үзүүлэх, тоо мэдээлэл боловсруулах систем боловсруулах зэрэг үйлчилгээ багтана. Гэрээний үнэд бүх зардал багтсан байх ба үнийг тохиролцохгүй. Төлбөрийг тайлан, зураг төсөл, ажлын тооцоо, тендерийн бичиг баримт, программ хангамж зэрэг ажлын үр дүнд үндэслэн олгоно.

5. Үр дүнд суурилсан гэрээ

2.49 Зөвлөх үйлчилгээний үр дүнг сайжруулснаар мөнгөний үнэ цэнийг өсгөх зорилгоор үр дүнд суурилсан гэрээг хэрэглэнэ. Төслийн тодорхой төлөвлөсөн үр дүн (жишээ нь: төслийн дизайн, мониторингийн хүрээнд заасан үр дүн) гарсан эсэхэд үндэслэн зөвлөхөд төлбөр төлнө. Гэрээний үе шатуудыг тодорхой зааж өгөх ба үр ашигтай хянаж, магадлаж болохуйц хангалттай тоо, үзүүлэлттэй байна. Ямар үе шатуудыг сонгох, ямар шалгуур үзүүлэлтээр тухайн үе шатанд хүрсэн эсэхийг магадлах талаар гэрээг хэлэлцэх үеэр зээлдэгч, зөвлөх нар тохиролцоно. Үе шатыг хялбар магадлаж болох эсэх нь төслийн шинж чанараас шалтгаална. Барилгын төслийн үе шатыг магадлах нь харьцангуй амархан бол бүтцийг бэхжүүлэх төслүүдэд нилээд төвөгтэй. Хоёр дахь тохиолдолд хугацаа, үр дүнгийн гэрээний зарчмуудыг хослуулах замаар тохиролцоонд хүрэх аргыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл, зөвлөхийн гэрээний үнийн тодорхой хувийг ажилласан хугацаанд, үлдсэн хувийг ихэвчлэн гэрээний эцэст нэг эсвэл хэд хэдэн гол үр дүн гарсан эсэхэд тус тус үндэслэн олгоно.

В. Зээлийн төслийн зөвлөх үйлчилгээний гэрээнд тусгагдах чухал заалтууд

2.50 Дараахь заалтуудыг зөвлөхийн гэрээнд тусгана.

1. Мөнгөний нэгж

2.51 Саналын урилгад зөвлөх компаниуд үйлчилгээнийхээ үнийг АХБ-ны гишүүн аль нэг улсын хөрвөх валютаар илэрхийлэхийг тодорхой дурьдсан байна. Хэрэв зөвлөхүүд үнээ хэд хэдэн өөр мөнгөний нэгжийн нийлбэр хэлбэрээр ирүүлэхийг хүсвэл мөнгөний нэгж нь гурваас илүүгүй байх ёстой. Зээлдэгч зөвлөхийн зардлын тодорхой хэсгийг зээлдэгчийн улс орны мөнгөний нэгжээр илэрхийлэн ирүүлэхийг зөвлөхөөс хүсч болно. Гэрээний төлбөрийг зөвлөхийн ирүүлсэн саналд тусгасан валют (валютууд)-аар хийнэ.

2. Үнийн тохируулга

2.52 Цалин хөлсийг гадаадын буюу дотоодын инфляцийн түвшинд тохируулан өөрчлөх үүднээс 18 сараас дээш хугацаанд үргэлжлэх гэрээнд үнийн дүнд тохируулга хийх заалт оруулна. Дотоодын буюу гадаадын инфляцийн түвшин өндөр, урьдчилан баримжаалахад төвөгтэй байх төлөвтэй байвал түүнээс богино хугацааны гэрээнд үнийн тохируулгын тухай заалт оруулж болно.

3. Төлбөр

2.53 Үнийн дүн, төлбөр хийх хуваарь, журам зэрэг төлбөртэй холбоотой заалтуудыг гэрээний хэлэлцээний үед тохирно. Төлбөрийг тогтмол зайтай хугацаанд (хугацааны гэрээнд), эсвэл ажлын бүтээмжид (бөөнд нь төлөх гэрээ) төлж болно. Ажил эхлүүлэх урьдчилгаа гэх мэт гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтэрсэн урьдчилгаа төлбөрийг төлөхдөө урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулна.

2.54 Төлбөрийг гэрээнд заасны дагуу шуурхай барагдуулна. Чингэхдээ дараахь зарчмыг баримтална. Үүнд:

- (а) Зээлдэгчийн хүсэлтээр АХБ-наас зөвлөхөд шууд төлбөр хийж болно. Эсвэл аккредитиваар дамжуулан төлбөр хийж болно.
- (б) Зөвхөн маргаантай үнийн дүнг саатуулах ба нэхэмжилсэн дүнгийн үлдсэн хэсгийг гэрээний дагуу төлнө.
- (в) Захиалагчийн буруугаас төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас хожимдуулсан тохиолдолд ногдуулах мөнгөн торгуулийн хэмжээг гэрээнд заана.

4. Урьдчилгаа төлбөрийн баталгаа

2.55 Зээлдэгч зээлийн төсөл дээр ажиллах зөвлөхүүдэд урьдчилгаа төлбөр төлөхдөө тэднээс баталгаа гаргуулж болно.

5. Зээлдэгчийн хувь нэмэр

2.56 Зээлдэгч өөрийн мэргэжилтнүүдээр янз бүрийн ажил гүйцэтгүүлж болно. Зээлдэгч ба зөвлөхийн хооронд байгуулсан гэрээгээр “зөвлөхтэй хамтран ажиллах ажилтан” гэж тодорхойлогдох ажилтан, орон сууц, оффис, нарийн бичгийн үйлчилгээ, цахилгаан, дулаан, ус, материал, тээврийн асуудлыг зохицуулна. Эдгээрийн аль нэг нь хангагдаагүй үед, эсвэл ажлын явцад тэдгээрийг эргүүлэн татах тохиолдолд зөвлөх ямар арга хэмжээ авч болох, зөвлөхөд ямар нөхөн төлбөр төлөхийг гэрээнд тодорхой тусгана.

6. Ашиг сонирхлын зөрчил

2.57 Тухайн этгээд албан үүрэг, хариуцлагаа гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хууль тогтоомж мөрдөхөд нь зүй бусаар нөлөөлөхүйц ашиг сонирхолтой бөгөөд тэрхүү ашиг сонирхлын зөрчил нь АХБ-ны авилгалын эсрэг бодлогод хориглосон үйл ажиллагааг бүрдүүлэх, эсвэл бүрдүүлэхэд нөлөөлөх бол АХБ ашиг сонирхлын зөрчил гэж үзнэ. АХБ-ны авилгалын эсрэг баримталдаг бодлого нь зээлдэгчдийг (АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шимийг хүртэгчид) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний хүрээнд үйлчилгээ үзүүлэх зөвлөхүүдийг ёс зүйн дээд зэргийн хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Хэрэв ашиг сонирхлын зөрчлийн улмаас аливаа зөвлөх сонгон шалгаруулах үйл явц шударга бус явагдсан гэж АХБ үзвэл тийм нөхцлийг зохицуулах арга хэмжээ авах, эсвэл гэрээ байгуулах эрх олгохоос татгалзах эрхтэй. Энэхүү журмын 1.11 дүгээр зүйлд заасны дагуу компаний зөвлөх үйлчилгээнээс шууд үүдэн гарсан, эсвэл түүнтэй шууд холбоотой өөр ажлуудад тухайн зөвлөхийг цаашид ажиллуулахыг хязгаарласан заалтыг зөвлөхийн гэрээнд тусгана.

7. Мэргэжлийн хариуцлага

2.58 Зөвлөх нь ажлыг тухайн салбарт мөрдөгддөг стандартын дагуу хичээнгүй нямбай гүйцэтгэх үүрэгтэй. Зөвлөхийн зээлдэгчийн өмнө хүлээх хариуцлага нь холбогдох хуулиар зохицуулагдах тул талууд энэ хариуцлагыг хязгаарлахаас бусад тохиолдолд гэрээнд энэ талаар заалт оруулах шаардлагагүй. Хэрэв талууд хариуцлагыг хязгаарлах талаар заалт оруулах бол дараахь нөхцлүүдийг хангасан байна: (а) зөвлөх илт хайхрамжгүй байдлаар алдаа гаргасан, эсвэл санаатай буруутай үйлдэл хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагад ямар нэг хязгаарлалт байж болохгүй. (б) зөвлөхийн зээлдэгчийн өмнө хүлээх хариуцлага ямар ч тохиолдолд гэрээний нийт үнийн дүнг тодорхой үржүүлэгчээр

үржүүлснээс бага байж болохгүй. Үржүүлэгчийн хэмжээг саналын урилга болон гэрээний тусгай нөхцөлд заах бөгөөд ийм хязгаарлалтын хэмжээ тухайн нөхцлөөс шалтгаална. (в) Ийм хязгаарлалт нь зөвхөн зөвлөхийн захиалагчийн өмнө хүлээх хариуцлагад хамаарах бөгөөд зөвлөхийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагад хамаарахгүй.

8. Зөвлөхүүдийг солих

2.59 Хэрэв ажлыг гүйцэтгэх явцад зөвлөхийн тодорхой нэг мэргэжилтний эрүүл мэнд муудах, нас барах, эсвэл ажилд тохирохгүй болох нь батлагдаж тухайн зөвлөхийг солих шаардлага гарвал зөвлөх компани наад зах нь ижил түвшний чадавхитай өөр нэг зөвлөхийг зээлдэгчид санал болгож түүний зөвшөөрлийг авна.

9. Мөрдөгдөх хууль, маргаан таслах

2.60 Гэрээнд мөрдөгдөх хууль, маргаан таслах арга замын талаар заалт оруулсан байна. Зөвлөхүүдтэй хийх гэрээнд аливаа маргааныг таслан шийдвэрлэх талаар заавал заалт оруулсан байна. Маргаан таслахад олон улсын худалдааны арбитрыг ашиглах нь бусад аргыг хэрэглэснээс практик давуу талтай тул зээлдэгч гэрээнд энэ аргыг зааж өгөх нь зүйтэй. АХБ өөрөө арбитражийн үүрэг гүйцэтгэхгүй, түүнчлэн арбитрч зааж өгөхгүй.

Г. Гүйцэтгэлийг хянах, үнэлэх

Сонгон шалгаруулах явцыг хянах

2.61 АХБ зээлийн болон ТТ-ны төсөлд зөвлөх сонгон шалгаруулах үйл ажиллагааг хянах (ЗСШҮАХ) системтэй. Тэр нь сонгон шалгаруулах үйл явцыг хэд хэдэн үйл ажиллагаанд хувааж, үйл ажиллагаа тус бүрт “норм” (тодорхой тооны ажлын өдөр) оноож үйл ажиллагаа нэг бүр болон нийт үйл явцыг дуусгах зорилтот хугацааг тооцоолдог. Мөн ЗСШҮАХБ системд (а) үйл ажиллагааг явуулах, (б) бодит хугацааг зорилтот хугацаатай харьцуулан хянах, (в) шаардлагатай бол цаг тухайд нь арга хэмжээ авах үүрэг хүлээх этгээдүүдийг томилсон байдаг. ЗСШҮАХБ-г бүх төрлийн сонгон шалгаруулах арга, техникийн саналд тохируулан ашиглаж болдог.

Гүйцэтгэлийг хянах

2.62 Зээлийн төсөл, зээлдэгчид хариуцуулсан ТТ-ны төслийн зөвлөхийн гүйцэтгэлд зээлдэгч, харин ТТ-ний төслийн зөвлөх гүйцэтгэлд АХБ зээлдэгчтэй зөвлөлдөн үнэлгээ хийдэг. Ажлын үргэлжлэх хугацаанаас хамааран үнэлгээг ажлын явцад, эсвэл эцэст нь дүгнэж болно. Ажил гүйцэтгэсний дараа зөвлөхөөр асуулга бөглүүлэх замаар үнэлгээний тайлан болон зээлдэгч, АХБ-ны өөрсдийнх нь гүйцэтгэлийн талаар саналаа илэрхийлэх боломж олгодог. Гэрээний хэлэлцээний үед зээлдэгч, эсвэл АХБ хэлэлцээ хийж байгаа

зөвлөхөд гүйцэтгэлийн үнэлгээний маягт, ажил гүйцэтгэсний дараа зөвлөхийн бөглөх асуулгын хуудсыг өгч, үнэлгээний тайлан гаргах, ажил гүйцэтгэсний дараа асуулгын хуудсыг бөглөх журмыг тайлбарлана. Ажил дуусмагц зээлдэгч, эсвэл АХБ зөвлөхийн ажилд үнэлгээ өгч нийт үнэлгээ, ялангуяа ямар нэг муу үнэлгээ байгаа бол түүнийг тайлбарласан нууц тайлан бэлтгэнэ. Энэ тайланг хожим нь зөвлөх компаний гүйцэтгэл хангалтгүй болох нь батлагдвал тухайн зөвлөхийг хожим сонгоход хязгаарлалт тавих, сонгохыг хориглоход ашиглаж болох юм. Зөвлөхийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээний дүнд болон зээлдэгч, АХБ-ны гүйцэтгэлийн талаар санал өгөх боломжийг зөвлөхөд олгоно. Зөвлөх компани болон хувь хүмүүсийн гүйцэтгэлийн талаар АХБ бүртгэл хөтөлдөг ба ТТ, зээлийн төслийн зөвлөхийн хураангуй жагсаалт гарах үед энэ бүртгэлийг үздэг.

Хавсралт 1

**ЧАНАР-ҮНИЙГ ХАРГАЛЗАХ СОНГОЛТ , ЧАНАРЫГ ХАРГАЛЗАХ СОНГОЛТООР
ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРМЫГ ХУРААНГУЙЛАН ҮЗҮҮЛСЭН НЬ**

Хүснэгт А1: Чанар үнийг харгалзах сонголтоор зөвлөх шалгаруулах журам

№	Зээл, зээлдэгчид хариуцуулсан	
	ТТ-ны төсөл	ТТ-ний төсөл
(i)	Ажлын даалгавар ба төсөвт өртгийг боловсруулах	Ажлын даалгавар ба төсөвт өртгийг боловсруулах
(ii)	Нийтэд зарлан мэдээлэх	Нийтэд зарлан мэдээлэх
(iii)	Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах	Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах
(iv)	Саналын урилга бэлтгэж зөвлөхүүдийн хураангуй жагсаалт гаргах	Саналын урилга бэлтгэж зөвлөхүүдийн хураангуй жагсаалт гаргах
АХБ-нд явуулах эхний материал ^a		
(v)	Саналын урилга тараах	Саналын урилга тараах
(vi)	Санал хүлээн авах	Санал хүлээн авах
(vii)	Техникийн саналыг үнэлэх	Техникийн саналыг үнэлэх
АХБ-нд явуулах хоёр дахь материал		
(viii)	Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх	Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх
(ix)	Санхүүгийн саналыг үнэлэх	Санхүүгийн саналыг үнэлэх
(x)	Саналыг онооны дагуу эрэмбэлэх	Саналыг онооны дагуу эрэмбэлэх
АХБ-нд явуулах гуравдахь материал ^a		
(xi)	Гарын үсэг зурсан гэрээний хувийг АХБ-нд явуулах	Гарын үсэг зурсан гэрээний хувийг АХБ-нд явуулах
(xii)	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх
(xiii)	Сонгон шалгаруулалтын дараа тайлбар өгөх	Сонгон шалгаруулалтын дараа тайлбар өгөх

^a Сонгон шалгаруулах чадавхитай нь батлагдсан Гүйцэтгэгч Агентлагууд (1.27, 2.3 дугаар зүйлийг үз.)

Хүснэгт А2: Чанарыг харгалзах сонголтоор зөвлөх шалгаруулах журам

№	Зээл, зээлдэгчид хариуцуулсан	
	ТТ-ны төсөл	ТТ-ний төсөл
(i)	Ажлын даалгавар ба төсөвт өртгийг боловсруулах	Ажлын даалгавар ба төсөвт өртгийг боловсруулах
(ii)	Нийтэд зарлан мэдээлэх	Нийтэд зарлан мэдээлэх
(iii)	Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах	Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах
(iv)	Саналын урилга бэлтгэж зөвлөхүүдийн хураангуй жагсаалт гаргах	Саналын урилга бэлтгэж зөвлөхүүдийн хураангуй жагсаалт гаргах
АХБ-нд явуулах эхний материал		
(v)	Саналын урилга тараах	Саналын урилга тараах
(vi)	Санал хүлээн авах	Санал хүлээн авах
(vii)	Техникийн саналыг үнэлж, эрэмбэлэх	Техникийн саналыг үнэлж, эрэмбэлэх
АХБ-нд явуулах хоёр дахь материал		
(viii)	Зээлдэгч техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөс санхүүгийн санал ирүүлэхийг хүсэх	АХБ техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөс санхүүгийн санал ирүүлэхийг хүсэх
(ix)	Шалгарсан зөвлөх компанитай хэлэлцээ хийж гэрээний төсөл бэлтгэх	Шалгарсан зөвлөх компанитай хэлэлцээ хийх
(x)	Гэрээнд гарын үсэг зурах	Гэрээнд гарын үсэг зурах
(xi)	Гарын үсэг зурсан гэрээний хувийг АХБ-нд явуулах	
(xii)	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх

АХБ = Азийн хөгжлийн банк, ЧХС = Чанарыг харгалзах сонголт, ТТ = Техник туслалцаа,

Хавсралт 2

ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙН ЗӨВЛӨХӨД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Зорилго

1.1 Энэ хавсралтад Азийн хөгжлийн банк (АХБ), тус банкны захиран зарцуулдаг бусад сангаас санхүүждэг зээлийн төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй зөвлөхүүдэд өгөх зөвлөмжийг багтаав.

Зөвлөхийг сонгон шалгаруулах үүрэг хариуцлага

1.2

- (i) Зээлийн төслийг хэрэгжүүлэх нь цэвэр зээлдэгчийн үүрэг хариуцлага тул төслийн зөвлөх үйлчилгээний төлбөрийг ч мөн зээлдэгч дангаараа хариуцна. АХБ өөрийн зүгээс гарсан зардлыг зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх үүрэг хүлээнэ.
- (ii) Зөвхөн зээлдэгчийн хүсэлтээр зээлийн хөрөнгөөс зарцуулалт хийнэ. Зээлдэгч зээлийн хөрөнгийг зээлийн гэрээний дагуу ашигласан болохыг батлах баримтуудыг данс зузаатгах өргөдлийн хамт АХБ-нд явуулна. Санхүүжилтийг (а) зээлдэгч өөрийн хөрөнгөөс нэгэнт хийсэн төлбөрийг нөхөн санхүүжүүлэх (б) гуравдагч этгээдэд (жишээ нь: зөвлөхөд) шууд төлбөр хийх зорилгоор хийнэ.
- (iii) Энэхүү журамд дурьдсанчлан зээлийн төслийн зөвлөхийг зээлдэгч сонгон шалгаруулдаг. Зээлдэгч саналын урилгыг явуулж, саналыг хүлээн авч, үнэлж, гэрээ байгуулах эрх олгодог. Гэрээг зээлдэгч, зөвлөхийн хооронд байгуулах бөгөөд АХБ гэрээнд тал болж оролцохгүй.

АХБ-ны үүрэг

1.3

- (i) Энэхүү журамд дурьдсанчлан зөвлөх сонгон шалгаруулах явц зээлийн гэрээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан журмын дагуу явагдсан эсэхийг баталгаажуулах зорилгоор саналын урилга, зөвлөхийн хураангуй жагсаалт, техникийн саналд хийсэн үнэлгээ, гэрээ байгуулах эрх олгох санал, гэрээг АХБ хянаж үздэг.
- (ii) АХБ сонгон шалгаруулах явцад (гэрээ байгуулах эрх олгогдсны дараа ч гэсэн) тохиролцсон журам нилээд хэмжээгээр зөрчигдсөн хэмээн дүгнэвэл энэхүү журмын 1.18 дугаар зүйлд заасанчлан АХБ сонгон шалгаруулалтыг хүчингүйд

тооцож болно. Зээлдэгч АХБ-наас “татгалзах зүйлгүй” болох тухай мэдэгдсний дараа гэрээ байгуулах эрх олгосон бол зөвхөн уг “татгалзах зүйлгүй” гэсэн мэдэгдлийг зээлдэгчийн ирүүлсэн дутуу, алдаатай, төөрөгдүүлсэн мэдээлэл дээр үндэслэн хийсэн тохиолдолд АХБ уг сонгон шалгаруулалтыг хүчингүй хэмээн зарлана.

- (iii) Хэрэв зээлдэгч эсвэл зөвлөхийн төлөөлөгч авилгал, хуурамчаар бүрдүүлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх болон бусад хориглосон үйл ажиллагааг явуулсан гэж АХБ үзвэл энэ журмын 1.23 (г) дэд зүйлд заасан хориг арга хэмжээг авч болно.
- (iv) Төрөл бүрийн зөвлөх үйлчилгээнд зориулсан саналын урилга, гэрээний стандарт загварыг АХБ-наас гаргадаг бөгөөд зээлдэгч тэдгээрийг заавал мөрдөн хэрэглэх үүрэгтэй. Төслийн өвөрмөц онцлогоос шалтгаалан АХБ-ны зөвшөөрөлтэйгээр эдгээр баримт бичигт бага зэрэг өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө. Зээлдэгч саналын урилга болон бусад баримт бичгийг эцэслэн боловсруулна.

Зөвлөх үйлчилгээний талаарх мэдээлэл

1.4 (i) Зөвлөх үйлчилгээний талаарх мэдээлэл, түүний дотор үйлчилгээний шинж чанар, хугацааны тов, төсөвт өртөг, хүн-сарын тоог хураангуй жагсаалт гарахаас 30-аас доошгүй хоногийн өмнө АХБ-ны вэбсайтад нийтэлнэ.

(ii) ТТ, зээлийн төслийн зөвлөхөд гэрээ байгуулах эрх олгосны дараа зээлдэгч дараахь мэдээллийг АХБ-ны вэбсайтад²⁶ тавиулахаар явуулна: (а) санал ирүүлсэн бүх зөвлөхүүдийн нэр (б) зөвлөхүүдийн техникийн саналд өгсөн оноо (в) зөвлөхүүдэд өгсөн нийт оноо (г) шалгарсан зөвлөхийн нэр, гэрээний үнийн дүн, үргэлжлэх хугацаа, гэрээний товч агуулга.

Зөвлөхийн үүрэг

1.5 (i) Саналын урилга хүлээж авсан зөвлөхүүд ажлын даалгавар, арилжааны болон гэрээний нөхцлийг биелүүлж чадах бол шаардлагад нийцсэн санал бэлтгэхэд шаардлагатай арга хэмжээг авна. Жишээлбэл: ажил гүйцэтгэх улс оронтой танилцаж, хамтрах дотоодын зөвлөх эрж хайх, мэдээлэл цуглуулах, ажилд бэлтгэх баг бүрдүүлэх гм. Хэрэв зөвлөх саналын урилгад, ялангуяа сонгон шалгаруулах журам, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд ямар нэг хоёрдмол утга, дутуу орхисон зүйл, хоорондоо зөрчилтэй, тодорхой бус, эсвэл ялгаварлан гадуурхсан, хязгаарласан шинжтэй заалт байна гэж үзвэл саналын урилгад заасан тодруулга хийх хугацаанд багтан тэр асуудлаар зээлдэгчээс бичгээр тодруулга хүснэ. Энд сонгон шалгаруулалт бүрийг тухайн сонгон шалгаруулалтад зориулан

²⁶ www.adb.org

зээлдэгчийн гаргасан саналын урилгаар зохицуулдаг гэдгийг онцлон дурьдах хэрэгтэй. Хэрэв саналын урилгын аль нэг заалт энэхүү журамтай нийцэхгүй байна гэж зөвлөх үзвэл энэ асуудлыг зээлдэгчид тавина.

(ii) Зөвлөхүүд шаардлагад бүрэн нийцсэн санал бэлтгэж түүнийгээ саналын урилгад дурьдсан шаардлагатай бүх баримтуудын хамт ирүүлэх үүрэгтэй. Саналд багтсан зөвлөхүүд анкетаа үнэн зөв ирүүлэх шаардлагатай. Анкетын үнэн зөв, зөвлөхийн бэлэн байдлыг батлан анкетад он сар өдрийг тавьж гарын үсэг зурсан байна. Шаардлагыг биелүүлээгүй саналыг хүлээж авахгүй. Техникийн саналыг хүлээн авч нээсний дараа саналын үндсэн хэсэг, мэргэжилтнүүд, бусад зүйлд өөрчлөлт хийхийг зөвлөхүүдэд шаардахгүй, зөвшөөрөхгүй. Үүнтэй адилаар санхүүгийн саналыг хүлээж авсны дараа саналын урилгад заасны дагуу хэлэлцээ хийхээс бусад үед санал болгосон үнэ болон бусад зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөхгүй. Хэрэв саналын хүчинтэй хугацааг сунгасны улмаас санал болгосон зөвлөх биеэ бэлэн байлгаж чадахгүйд хүрвэл түүнтэй адилтгахуйц, эсвэл түүнээс илүү чадавхитай өөр зөвлөхөөр сольж болно.

Нууцлал

1.6 2.13 дугаар зүйлд заасны дагуу техникийн саналд өгсөн өгсөн оноог нийтэд зарлах, 2.14 дүгээр зүйлд заасны дагуу санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх үед санхүүгийн саналыг зарлахаас бусад тохиолдолд энэ журмын 2.21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд үнэлгээний явцыг нууцлана. Ийнхүү нууцлах нь сонгон шалгаруулалтад зүй бусаар хөндлөнгөөс оролцох, эсвэл оролцох боломжтой гэсэн ойлголт төрүүлэхээс сэргийлэх боломжийг зээлдэгч, АХБ-ны хянагч нарт олгодог.

Сонгон шалгаруулах явцад гарах гомдол

1.7 Хэрэв зөвлөхүүд сонгон шалгаруулалт шударга байдлаар явагдаж байгаад эргэлзэж байгаагаа зээлдэгч, АХБ, эсвэл аль алиных нь сонорт хүргэхийг хүсвэл тэд энэ тухай зээлдэгчээр дамжуулан бичгээр АХБ-нд мэдэгдэнэ. Хэрэв зээлдэгч шуурхай хариу өгөхгүй, эсвэл зөвлөх зээлдэгчийн эсрэг гомдол мэдүүлэх гэж байгаа бол шууд АХБ-нд хандан гомдлоо бичгээр гаргаж болно.

Гэрээ байгуулах эрх олгосны дараа тайлбар хүсэх

1.8 Хэрэв гэрээ байгуулах эрх олгосны дараа аль нэг зөвлөх саналыг нь ямар үндэслэлээр шалгаруулаагүй тухай мэдэхийг хүсвэл зээлдэгчид хандан тайлбар хүсч болно. Хэрэв зөвлөх зээлдэгчийн өгсөн тайлбарыг хангалтгүй гэж үзвэл АХБ-нд хандан бичгээр тайлбар хүсч болно.